

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-22
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	23-47
<hr/>	
<i>1. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	23-45
<i>2. “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	45
<i>3. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	45-47

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
06 дугаар сарын 28-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 33 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: С.Бямбацогт, Г.Ганболд, Т.Доржханд, Б.Пүрэвдорж, Л.Оюун-Эрдэнэ, Х.Нямбаатар, Д.Сарангэрэл;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг.

Нэг.Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор О.Мөнхсайхан, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, Монгол Улсын Боловсролын Их сургуулийн багш Э.Гэрэлт-Од, судлаач Д.Энхцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Б.Галсанбат, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн талаарх ажлын хэсгийн гаргасан тусгайлсан саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “гишүүн” гэснийг, 3.1.7 дахь заалтын “биет ба биет бус хөрөнгө,” гэснийг, 3.1.14 дэх заалтын “шууд, эсхүл шууд бус” гэснийг болон 3.1.13 дахь заалтыг тус тус хасаж, 3.1.3 дахь заалтын “сонгогдсон” гэсний дараа “, томилогдсон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын “өдрийг” гэснийг “өдрөөс эхлэх жилийг” гэж өөрчилж, 3.1.6, 3.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.6.“намын санхүүгийн тайлан” гэж тайлант хугацаанд намаас энэ хуульд заасны дагуу гаргасан болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д заасан тайлангийн цахим болон хэвлэмэл мэдээллийн бүрдлийг;

3.1.8.“төрийн санхүүжилт” гэж нам чиг үүргээ хэрэгжүүлэхэд зориулж, санхүүжилтийн зохих хэсэгт нь төрөөс мөнгөн хэлбэрээр олгож буй санхүүгийн дэмжлэгийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 4.2.2 дахь заалтын “ард түмний” гэснийг “иргэдийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “болон тухайн намыг” гэснийг хасаж, 5.9 дэх хэсгийн “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх” гэсний дараа “болон холбогдох бусад” гэж нэмж, 5.10 дахь хэсгийн “үзэл бодлоор” гэснийг “үзэл бодол, боловсрол зэргээр” гэж, 5.13 дахь хэсгийн “үүсгэн байгуулахад оролцохыг” гэснийг “үүсгэн байгуулах, гишүүнээр элсэхийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийн “24 жилийн” гэснийг “12 жилийн” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.8 дахь хэсэг нэмэх:

“6.8.Улсын дээд шүүхийн Тамгын газар намын нэрийн санг хөтөлж, лавлагаа олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “байгууллагын бүрэлдэхүүнийг сонгоход болон төрийн улс төрийн албан тушаалд намаас санал болгож сонгогдох, томилогдох нэр дэвшигчийг тодруулахад” гэснийг “байгууллагыг бүрдүүлэхдээ” гэж өөрчилж, 8.2.3 дахь заалтын “аль нэг хүйсийн” гэсний өмнө “нэр дэвшүүлэхдээ” гэж нэмж, 8.8 дахь хэсгийг 8.8, 8.9 дэх хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.8.Жендэрийн үндэсний хороо энэ хуулийн 8.2.3, 17.7-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг жил бүрийн 08 дугаар сарын 01-ний дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

8.9.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 8.8-д заасан дүгнэлтийг үндэслэн зөрчлийг арилгах талаарх шаардлагыг тухайн намд хүргүүлэх бөгөөд хүргүүлсэн өдрөөс хойш зургаан сарын дотор уг зөрчлийг арилгаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл төрийн санхүүжилтийг зогсооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “цахимаар явуулж болно. Ингэхдээ сонгуулийн төв байгууллагаар баталгаажсан программ хангамжийг ашиглана” гэснийг “аюулгүй байдлыг хангасан программ хангамж ашиглан намын дүрэмд заасны дагуу цахимаар явуулж болно” гэж, 9.7 дахь хэсгийн “Шилэн дансны тухай хуульд заасны дагуу намын” гэснийг “холбогдох хуульд заасны дагуу” гэж, “хувь хүний хуулиар хамгаалбал зохих мэдээллээс бусад мэдээллийг мэдээлнэ” гэснийг “энэ хуулийн 43.8-д заасныг баримтална” гэж, 9.9 дэх хэсгийн “9.6.1-9.6.7-д” гэснийг “9.6.1, 9.6.3, 9.6.4, 9.6.5, 9.6.7, 9.6.8, 9.6.9, 9.6.10, 9.6.11, 9.6.12-д” гэж, 9.10 дахь хэсгийн “9.6.1-9.6.7-д” гэснийг “9.6.1-9.6.12-д” гэж тус тус өөрчилж, 9.4 дэх хэсгийн “Цахим хуралдаан, санал хураалтын үр дүнд гарсан шийдвэрийг хүчинтэйд тооцно.” гэсэн эхний өгүүлбэрийг хасаж, 9.6.9 дэх заалтын “намын” гэсний дараа “болон харьяа байгууллагын” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 9.6.4 дэх заалт нэмэх:

“9.6.4.намын сонгуулийн мөрийн хөтөлбөр;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “тусгаар тогтнол,” гэсний дараа “бүрэн эрхт байдал,” гэж, 10.1.3 дахь заалтын “гүйцэлдүүлэх”

гэсний дараа “үйл ажиллагаа явуулах” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 10.1.3 дахь заалтын “үймээн самуун дэгдээх,” гэснийг хасаж, 10.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.4.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол зэргээр нь ялгаварлан гадуурхах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.5 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллагад” гэснийг “Улсын дээд шүүхэд” гэж, 12.2 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллагад” гэснийг “Улсын дээд шүүхийн” гэж, 12.3.5 дахь заалтын “хаягийн нотлох баримт” гэснийг “хаягийн мэдээлэл” гэж тус тус өөрчилж, 12.3.7 дахь заалтын “намын санхүүгийн асуудал” гэсний өмнө “намын дарга,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 12.6 дахь хэсэг нэмэх:

“12.6.Энэ хуулийн 12.3.6, 12.3.7, 12.3.8-д заасан мэдээллийн маягтыг Улсын дээд шүүх батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.5 дахь хэсгийн “Сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүх” гэж, 13.6 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллагад” гэснийг “Улсын дээд шүүхэд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 13.4 дэх хэсгийг хасаж, доор дурдсан агуулгатай 13.5, 13.6 дахь хэсэг нэмэх:

“13.5.Улсын дээд шүүх намын нэр энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн эсэхийг нягтлан шалгахдаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.1.5, энэ хуулийн 6.8-д заасан нэрийн санг ашиглана.

13.6.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 13.5-д заасан нэрийн санг ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор О.Мөнхсайхан нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “Сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүхийн Тамгын газар” гэж, 14.4 дэх хэсгийн “улсын бүртгэлд” гэснийг “намын бүртгэлд” гэж, 14.9 дэх хэсгийн “Сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүх” гэж тус тус өөрчилж, 14.3 дахь хэсгийн “гэрчилгээ” гэсний дараа “, тамга тэмдгийн хяналтын дугаар” гэж, 14.6 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэсний дараа “, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, “баримт бичиг” гэсний дараа “, лавлагаа,” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 14.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар энэ хуулийн 13.1, 13.2-т заасан хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн тухайн намыг намын бүртгэлд бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзах тухай шийдвэр гаргаж, Улсын дээд шүүхийн Тамгын газар ажлын гурван өдрийн дотор өргөдөл гаргагчид бичгээр болон цахимаар хүргүүлж, нийтэд мэдээлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.7, 14.11 дэх хэсэг тус тус нэмэх:

“14.7.Энэ хуулийн 12.2, 12.3, 12.4, 15.3, 21.1, 21.4-т заасан болон бусад мэдээлэл, баримт бичиг, түүнд оруулсан өөрчлөлтийг холбогдох бусад байгууллагад хүргүүлэх журмыг Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, сонгуулийн төв байгууллагын дарга хамтран батална.

14.11.Намыг бүртгэхтэй холбоотой журмыг сонгуулийн төв байгууллага, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан энэ хууль болон бусад хуульд нийцүүлэн Улсын дээд шүүх батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах”

“15.4.Улсын дээд шүүхийн Тамгын газар энэ хуулийн 15.3-т заасан шийдвэртэй холбоотой мэдээллийг бүртгэж энэ тухай нийтэд мэдээлж, сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 17.2.2 дахь заалтын “жил тутам” гэснийг “жилийн хугацаанд” гэж, 17.2.2 дахь заалтын “болон” гэснийг “бүрэлдэхүүнийг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгох, эсхүл батламжлах” гэж тус тус өөрчилж, 17.3 дахь хэсгийн “Намын дүрэмд заасан тохиолдолд” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.4 дэх хэсэг нэмэх:

“17.4.Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.4, 19.5, 19.6 дахь хэсэг тус тус нэмэх:

“19.4.Нам бүх шатны сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгон шалгаруулах хороотой байх бөгөөд хорооны бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, түүнийг байгуулах, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах болон үйл ажиллагааны журмыг энэ хуулийн 8 дугаар зүйл, намын дүрэмд нийцүүлнэ.

19.5.Энэ хуулийн 19.4-т заасан хороо нь нэр дэвшигчийг сонгон шалгаруулахдаа энэ хуулийн 8.2.1, 8.2.2, 8.3-д заасныг баримталж, тухайн албан тушаалыг хаших ёс зүйн болон хууль тогтоомж, холбогдох журмаар тогтоосон бусад шаардлагад үндэслэнэ.

19.6.Энэ хуулийн 19.4, 19.5-д заасан журмыг намын төлөөллийн төв байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “төрийн санхүүжилтийг зогсоох бөгөөд” гэсний дараа “зөрчлийг арилгах хүртэл” гэж, 21.4 дэх хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэсний дараа “Улсын дээд шүүхэд хүргүүлэх бөгөөд Улсын дээд шүүх” гэж, 21.5 дахь хэсгийн “дуусах хүртэл намыг” гэсний дараа “идэвхтэй, эсхүл” гэж тус тус нэмж, 21.5 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүх” гэж өөрчилж, 21.6 дахь хэсгийг хасаж, 21.1, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Улсын дээд шүүх сонгуулийн төв байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн дараах тохиолдолд намыг идэвхгүйд тооцох тухай шийдвэрийг гаргана:

21.3.Энэ хуулийн 21.1.1-д заасан зөрчил гаргасан намын эрх бүхий байгууллага сонгуульд оролцох шийдвэр гаргаж, сонгуулийн төв байгууллагад бүртгүүлсэн, эсхүл энэ хуулийн 21.1.2, 21.1.3-т заасан зөрчлөө арилгасан талаар холбогдох нотлох баримтыг сонгуулийн төв байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 21.6 дахь хэсэг нэмэх:

“21.6.Энэ зүйлд заасны дагуу гаргасан Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “хуульд өөрөөр заагаагүй бол” гэсний дараа “сонгуулийн төв байгууллага” гэж нэмж, 22.2 дахь хэсгийг 22.2, 22.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.Улсын дээд шүүх энэ хуулийн 23.1, 24.1-д заасан шийдвэрийг хүлээн авснаас, эсхүл 25.3-т заасан шийдвэрийг гаргаснаас хойш ажлын таван өдрийн дотор тухайн намыг бүртгэлээс хасаж гэрчилгээ, тамга тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгоно.

22.3.Улсын дээд шүүхийн Тамгын газар энэ хуульд заасны дагуу намыг татан буулгасан тухай шийдвэр, шаардлагатай бусад мэдээллийг сонгуулийн төв байгууллага болон бусад этгээдэд хүргүүлж, нийтэд мэдээлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “Сонгуулийн төв байгууллагад” гэснийг “Улсын дээд шүүхэд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “сонгуулийн төв байгууллагад” гэснийг “Улсын дээд шүүхэд” гэж өөрчилж, 24.2 дахь хэсгийг 24.2, 24.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.2.Энэ хуулийн 22.2-т заасны дагуу шийдвэр гарсан бол татан буулгах комисс намын өр төлбөрийг барагдуулж дууссаны дараа үлдсэн хөрөнгийг сонгуулийн төв байгууллагад шилжүүлнэ.

24.3.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 24.2-т заасны дагуу шилжүүлсэн хөрөнгийг иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэхэд зарцуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.2, 25.3 дахь хэсгийн “дүгнэлтийг” гэснийг “саналыг” гэж өөрчилж, 25.3 дахь хэсгийн “шийдвэр гаргаж,” гэсний дараа “Улсын дээд шүүхийн Тамгын газар” гэж нэмж, мөн зүйлийн 25.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.1.Энэ хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3-т заасан хориглолтыг зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн бол сонгуулийн төв байгууллага намыг тараах тухай үндэслэл бүхий санал гаргаж, холбогдох нотлох баримт, хуралдааны тэмдэглэлийн хамт Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.5 дахь заалтын “энэ хуулийн 36.3-т заасан” гэснийг “энэ хуулиар зөвшөөрсөн” гэж, 26.4 дэх хэсгийн “үйл ажиллагааг санхүүжүүлэх замаар” гэснийг “үйл ажиллагаанд” гэж, 26.8 дахь хэсгийн “цахим мөнгөн хэрэгсэл /крипто валют, NFT зэрэг/-ээр” гэснийг “цахим мөнгөөр” гэж тус тус өөрчилж, 26.6 дахь хэсгийн “зарцуулсан бол” гэсний дараа “сонгуулийн төв байгууллага” гэж, 26.7 дахь хэсгийн “хүлээн авах бөгөөд өөр” гэсний дараа “харилцах” гэж тус тус нэмж, 26.7 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3

Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “0.5 хувиар” гэснийг “0.7 хувиар” гэж, 27.3 дахь хэсэг, 27.6.1 дэх заалтын “2-оос” гэснийг “нэг ба түүнээс” гэж, 27.6.5 дахь заалтын “50 дахин” гэснийг “25 дахин” гэж, 27.9 дэх хэсгийн “36.3.1-36.3.3-д” гэснийг “36.3.1-36.3.4-т” гэж тус тус өөрчилж, 27.11 дэх хэсгийн “Нам тарах,” гэснийг болон мөн зүйлийн 27.8 дахь хэсгийг тус тус хасаж, доор дурдсан агуулгатай 27.10, 27.12, 27.13 дахь хэсэг тус тус нэмэх:

“27.10.Эвслийн гэрээнд өөрөөр заагаагүй энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн (С1 * Т1) хэсгийг эвсэлд нэгдсэн намуудад тэнцүү хувааж, төрийн санхүүжилтийн (С2 * Т2) хэсгийг тухайн суудалд сонгогдсон гишүүнийг нэр дэвшүүлсэн намд олгоно.

27.12.Намд олгох төрийн санхүүжилтийг жил бүр сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад суулгаж, батлуулна.

27.13.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу намын төв байгууллагад олгох бөгөөд салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг намын дүрмээр зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “Энэ хуулийн 28.1-д заасан” гэснийг “Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ” гэж, “30 хоногийн” гэснийг “долоо хоногийн” гэж, 28.2 дахь хэсгийн “гаргасан” гэснийг “баталсан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “2 удаа” гэснийг, 29.5 дахь хэсгийн “суурь” гэснийг, 29.10 дахь хэсгийн “давж” гэснийг тус тус хасаж, 29.4 дэх хэсгийн “нягтлан шалгах ажиллагаа явуулж буй бол уул ажиллагаа дууссаны дараа” гэснийг “хянасны дараа” гэж, 29.5 дахь хэсгийн “төрийн санхүүжилт авах намын эрх үүссэн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрөөс” гэснийг “төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилээс” гэж, 29.6 дахь хэсгийн “энэ хуулийн 27.5-д заасны дагуу тухайн намын авсан хүчинтэй саналын тоо (С1)-нд суурилсан төрийн санхүүжилтийн хэсгийг” гэснийг “энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн (С1 * Т1) хэсгийг дараагийн жилд” гэж, 29.7 дахь хэсгийн “Тайлангийн агуулга алдаа, зөрчилтэй эсэхээс үл хамааран тайлангаа” гэснийг “Санхүүгийн тайлангаа” гэж, “гэмдэглэлийн” гэснийг “дүгнэлтийн” гэж, 29.9 дэх

хэсгийн “нийтлэгдсэн” гэснийг “тусгасан” гэж, “36.3.1-36.3.3-д” гэснийг “36.3.1-36.3.4-т” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “1 хувиас доошгүй” гэснийг “нэг ба түүнээс дээш хувийн” гэж, 30.1.1 дэх заалтын “зохион байгуулахад” гэснийг “зохион байгуулах, иргэдийг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх зорилгоор” гэж, 30.1.2 дахь заалтын “телевизээр жилд” гэснийг “телевизээс гаргасан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31 дүгээр зүйл.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт тавих хяналт

31.1.Сонгуулийн төв байгууллага төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалтын тайланг хянаж, хүлээн авч нэгтгэн тайлагнана.

31.2.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу намын санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээдээр хараат бусаар дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавина.

31.3.Төрийн аудитын байгууллага нь сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад туссан намд олгох төрийн санхүүжилт, түүний зарцуулалт, тайлагналд Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “намын дансаар” гэснийг “зөвхөн данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр намын дансанд” гэж, “тооцооны” гэснийг “харилцах” гэж тус тус өөрчилж, 33.4 дэх хэсгийн “үнэлэн бүртгэж” гэснийг болон 33.5 дахь хэсэг, мөн зүйлийн 33.13 дахь хэсгийн “байгууллагад өгөх” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн “тухайн улирлын хамаарах хагас жилийн төрийн санхүүжилтийг” гэснийг “сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн (С1 * Т1) хэсгийг дараагийн жилд” гэж өөрчилж, 34.6.5 дахь заалтын “, бусад удирдах албан тушаалтан” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 34.5.6 дахь заалт, 34.12, 34.13 дахь хэсэг тус тус нэмэх:

“34.5.6.мөнгөн бус хандив авч байгаа тохиолдолд хандивлагчтай хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах;

34.12.Хуулийн этгээд намд хандив өгсөн бол хандивын хэмжээ, зориулалтыг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайландаа тусгана.

34.13.Намын санхүүгийн тайланд аудит хийхээр гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд хандивын талаарх баримт, мэдээллийг хандивлагчаас гаргуулан авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийн “заасан худалдан борлуулах” гэснийг “заасны дагуу захиран зарцуулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн “хөрөнгийн баланс” гэснийг “хөрөнгийн бүртгэл” гэж, 36.3.7 дахь заалтын “арга хэмжээ зохион байгуулах, ном болон нийтлэл хэвлэн борлуулах үйл ажиллагаанаас” гэснийг “намтай холбоотой хэвлэл, сурталчилгааны материал болон өөрийн хөрөнгийг захиран зарцуулах замаар” гэж, 36.14 дэх хэсгийн “бодлогын судалгааны байгууллага зэрэг түүний дэргэдэх, харьяа байгууллагын санхүүгийн тайланг” гэснийг “намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж, харьяа байгууллагын санхүүгийн мэдээллийг” гэж тус тус өөрчилж, 36.3.5, 36.3.6, 36.4.9 дэх заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 36.5, 36.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.5.Хөрөнгөд дараах зүйлийг бүртгэнэ:

36.5.1.барилга;

36.5.2.эзэмшлийн газар;

36.5.3.ажлын байрны тоноглол, техник хэрэгсэл;

36.5.4.бэлэн мөнгөний үлдэгдэл;

36.5.5.хуримтлал;

36.5.6.бусад хөрөнгө.

36.6.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага намын санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, хөрөнгө, орлого, зарлагын ангиллыг тодорхойлон

тайлагнах журмыг сонгуулийн төв байгууллагатай хамтран энэ хуульд нийцүүлэн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн “тайлангаа нэгдсэн байдлаар” гэснийг “нэгтгэсэн тайланг” гэж, 37.6 дахь хэсгийн “бүртгэл болон санхүүгийн” гэснийг “бүртгэлийн” гэж тус тус өөрчилж, 37.2 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр, 37.4.1 дэх заалтын “намын гишүүний тоо.” гэснийг, 37.7 дахь хэсгийн “, эсхүл төлөөллийн төв байгууллагагүй бол удирдах дээд байгууллагаас” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн гарчгийн “Тайланг аудитын байгууллагаар” гэснийг “Санхүүгийн тайланг” гэж, 38.2, 38.9 дэх хэсгийн “Аудитор” гэснийг “Аудитын хуулийн этгээд” гэж, 38.2 дахь хэсгийн “баримт материалтай” гэснийг “баримт бичигтэй” гэж, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийн “аудиторын” гэснийг “аудитын” гэж, 38.5 дахь хэсгийн “тохиолдолд” гэснийг “этгээд” гэж, 38.9 дэх хэсгийн “тайланг гаргахад хэрэглэсэн баримт бичиг, нягтлан бодох бүртгэл,” гэснийг “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт,” гэж, 38.10 дахь хэсгийн “баталгаа гарахад хангалттай” гэснийг “баталгаа гаргана” гэж, 38.14 дэх хэсгийн “Шалгалтын тэмдэглэлийг” гэснийг “Аудитын дүгнэлтийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 38.6, 38.8, 38.13 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.7, 38.12 дахь хэсгийг 38.1, 38.5, 38.9 дэх хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.1.Нам жилийн эцсийн санхүүгийн тайланд жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Аудитын тухай хуульд заасан шаардлагыг хангасан аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан аудит хийсэн санхүүгийн тайланг сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

38.5.Энэ хуулийн 38.1-д заасан аудитын хяналтыг хийхдээ намын санхүүгийн тайлан болон аудитын хуулийн этгээдийн илрүүлсэн эрсдэлд үндэслэн орон нутгийн салбар нэгж байгууллагын таваас доошгүй хувийг түүвэрт хамруулна.

38.9.Аудитын хуулийн этгээд намын санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэл, бусад баримт бичиг болон намын гүйцэтгэх төв байгууллагаас өгсөн тайлбар, тодруулгыг үндэслэн холбогдох олон улсын стандартын дагуу шалгаж, баталгаажуулан дүгнэлт, тайлан гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн тавьсан асуултад Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн гарчгийн “тайланг нягтлан шалгах” гэснийг “тайлангийн хяналт” гэж, 39.1 дэх хэсгийн “хэлбэр болон агуулгын хувьд зөв, бодитой эсэх, энэ хуулийн Тавдугаар бүлэгт” гэснийг “энэ хуульд” гэж, “нягтлан шалгах” гэснийг “хянах” гэж, 39.2 дахь хэсгийн “ажлын 15-аас” гэснийг “ажлын таваас” гэж, 39.3 дахь хэсгийн “хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн” гэснийг “хүлээн авч хянаад 4 дүгээр сарын 05-ны” гэж, 39.4 дэх хэсгийн “Нягтлан шалгах ажиллагаа” гэснийг “Хяналтын ажиллагаа” гэж, 39.5 дахь хэсгийн “тухайн алдаа, зөрчлийг арилгаж сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу” гэснийг “аудитын хуулийн этгээдийн тогтоосон хугацаанд тухайн алдаа, зөрчлийг арилгаж,” гэж, 39.7 дахь хэсгийн “Тайланг нягтлан шалгах ажиллагааны” гэснийг “Санхүүгийн тайланг хянах” гэж тус тус өөрчилж, 39.4.3, 39.4.4, 39.6 дахь хэсгийг болон мөн зүйлийн 39.7 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 39.5 дахь хэсэг нэмэх:

“39.5.Төрийн аудитын байгууллага төрөөс намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусган тайлагнана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “мэдүүлэх” гэснийг “мэдэгдэх” гэж, 40.2 дахь хэсгийн “нягтлан шалгах ажиллагааны явцад” гэснийг “хянах явцад” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн гарчгийн “Төрөөс олгосон санхүүжилтийг буцааж төлөх” гэснийг “Аудитын дүгнэлтээр тогтоосон алдаа, зөрчлийн үр

дагавар” гэж өөрчилж, 41.2, 41.3 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 41.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41.1.Энэ хуулийн 39.6-д заасан хугацаанд алдаа, зөрчлөө арилгаж, санхүүгийн тайлангаа шинэчлэн ирүүлээгүй бол сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн (C1 * T1) хэсгийг дараагийн жилд олгохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийн гарчгийн “, эсхүл ил болгоогүй” гэснийг болон 42.4 дэх хэсгийг тус тус хасаж, 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Нам энэ хуулийн 34.5.3, 34.5.4-д заасны дагуу хандивыг шилжүүлээгүй бол сонгуулийн төв байгууллагын шийдвэрээр тухайн нам хууль бусаар авсан хандивыг гурав дахин өсгөсөн дүнгээр сонгуулийн төв байгууллагад төлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дэх хэсгийн “4 дүгээр сард” гэснийг “5 дугаар сард” гэж, “зохих тоогоор” гэснийг “тухай бүр эмхэтгэж” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн 44.2.2 дахь заалтын “болон тарсан” гэснийг хасаж, мөн зүйлийг 7 дугаар зүйлд нэгтгэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал хариулж, тайлбар хийв.

Найруулгын санал

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3.1 дэх заалтын “нийгмийн” гэсний дараа “сонирхлын” гэж тус тус, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн “албан тушаалтны зүгээс” гэсний дараа “заналхийлэх,” гэж, 29 дүгээр зүйлийн 29.3, 29.6 дахь хэсгийн “тайланг” гэсний өмнө “санхүүгийн” гэж, 29.9 дэх хэсгийн “тайланд” гэсний өмнө “санхүүгийн” гэж тус тус нэмж, 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын “төрийн санхүүжилт авах эрх үүсэх жил” гэснийг “төрийн санхүүжилтийн эрх үүсэх жил” гэж, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “мөшгөн хавчих” гэснийг “мөрдөн мөшгөх” гэж, 5.6 дахь хэсгийн “бичиг баримтад” гэснийг “баримт бичигт” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын “хуульд тогтоомжид” гэснийг “хууль тогтоомжид” гэж, 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн “байдлын” гэснийг “байдлыг хангах” гэж, 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсгийн “хийж” гэснийг “хийлгэж” гэж, 12.3.8 дахь заалтын “хөрөнгийн мэдээ” гэснийг “хөрөнгийн мэдээлэл” гэж, 12.4 дэх хэсгийн “хөрөнгийн мэдээнд” гэснийг “хөрөнгийн мэдээлэлд” гэж, 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтын “гишүүнчлэлээс” гэснийг “гишүүнээс” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “10 хоногийн” гэснийг “10 өдрийн” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “гишүүдийн” гэснийг “гишүүний” гэж, 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн “Улсын дээд шүүх” гэснийг “Улсын дээд шүүхийн” гэж, 29.9 дэх хэсгийн “тооцон бодоход” гэснийг “тооцоолоход” гэж, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “шийдвэрлүүлнэ” гэснийг “шийдвэрлэнэ” гэж, 36 дугаар зүйлийн 36.16 дахь хэсгийн “баримтыг” гэснийг “баримт бичгийг” гэж тус тус өөрчилж, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “зорилго, бодлогыг тодорхойлсон” гэсний дараах “үндсэн” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсгийн “хэдийд ч” гэсний дараах “намаас” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтын “нам” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.4.3 дахь заалтын “буюу” гэснийг, 30 дугаар зүйлийн 30.1.2, 30.3 дахь хэсгийн “үндэсний” гэснийг тус тус хасах.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

1.Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “энэ хуульд нийцүүлэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хуультай нийцүүлэх арга хэмжээг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш 6 сарын дотор авч хэрэгжүүлэх бөгөөд энэхүү өөрчлөлтөө Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, намын санхүүгийн тайлан гаргах, тайланг нийтэд мэдээлэх, намыг идэвхгүйд тооцохтой холбоотой зохицуулалт нь Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн өдрөөс хэрэгжинэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх.

“2 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “Улс төрийн нам, шашны байгууллагыг” гэснийг “Шашны байгууллагыг” гэж, 15.2.3, 15.2.4, 15.2.5 дахь заалтын дугаарыг “15.2.1, 15.2.2, 15.2.3” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “арван мянган нэгжтэй” гэснийг “тухайн мөнгөн дүнг, эсхүл мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээг зах зээлийн дундаж ханшаар үнэлсэн дүнг нэг аравны тав дахин үржүүлсэнтэй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “нэг банк дахь нэг дансаар хүлээн аваагүй бол арван мянган нэгжтэй” гэснийг “банкны нэг дансаар хүлээн аваагүй бол тухайн орлогын мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “арван мянган нэгжтэй” гэснийг “тухайн мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “арван мянган нэгжтэй” гэснийг “тухайн хандивын мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

5.Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтын “энэ хуулийн 3.1.6-д заасны дагуу” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

6.Хуулийн этгээдийн улсын бүртгэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төсөл

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.2 дахь хэсэг нэмсүгэй:

“3.2.Улс төрийн намыг шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг намын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, намын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэ хууль үйлчлэхгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

7.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх.

“1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 85 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 85.6 дахь хэсэг нэмсүгэй.

“85.6.Улсын дээд шүүхийн Тамгын газар нь энэ хуулийн 25.8.8-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий нэгжтэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 25.8.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.8.8.Улс төрийн намыг бүртгэх, бүртгэхээс татгалзах, идэвхгүй болон идэвхтэйд тооцох, татан буулгах, тамга тэмдгийн хяналтын, регистрийн, хувийн хэргийн дугаар, гэрчилгээ олгох, хүчингүй болгох, эдгээртэй холбогдсон бүртгэл болон намын нэрийн сан хөтлөх, лавлагаа олгох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Энхболд: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 25.8.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.8.8.Улс төрийн намыг бүртгэх, бүртгэхээс татгалзах, идэвхгүй болон идэвхтэйд тооцох, татан буулгах, тамга тэмдгийн хяналтын, регистрийн, хувийн хэргийн дугаар, гэрчилгээ олгох, хүчингүй болгох, эдгээртэй холбогдсон бүртгэл болон намын нэрийн сан хөтлөх, лавлагаа олгох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

8.Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “ажлын албанд” гэснийг “Тамгын газарт” гэж, 15 дугаар зүйлийн гарчгийн “ажлын алба” гэснийг “Тамгын газар” гэж, 15.1 дэх хэсгийн “ажлын албатай” гэснийг “Тамгын газартай” гэж, мөн хэсгийн “Хороо батална.” гэснийг “Хороо батална. Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг Улсын Их Хурал тогтооно.” гэж, 15.2 дахь хэсгийн “ажлын албаны” гэснийг “Тамгын газрын” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хасаж, 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6. Хороо улс төрийн намын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.6.1. Улс төрийн намын тухай хуулийн 9.10-т заасан мэдээллийн сан бүрдүүлж, нийтэд мэдээлэх;

7.6.2. төрийн санхүүжилт авах тухай хүсэлт гаргах маягтыг батлах;

7.6.3. намд өгөх хандивын бүртгэлийг хөтлөх маягтыг батлах;

7.6.4. хуульд заасан үндэслэл журмын дагуу намыг тараах тухай санал гаргах;

7.6.5. намд олгох төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоож, төсөвт суулган олгох;

7.6.6. намд төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг олгох, шийдвэрлэх;

7.6.7. Улс төрийн намын тухай хуулийн 8.9, 10.3-т заасны дагуу хяналт хэрэгжүүлэх;

7.6.8. Улс төрийн намын тухай хуулийн 26.6-д заасны дагуу шийдвэр гаргах;

7.6.9. улс төрийн намын санхүүгийн тайланд хяналт тавих;

7.6.10. Улс төрийн намын тухай хуульд заасан бусад бүрэн эрх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

9. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Н.Энхболд: 1. Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн “нарийвчилсан журам, арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар

/Л.Оюун-Эрдэнэ/,” гэснийг “журам батлах, зохион байгуулалтын холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын дээд шүүх /Д.Ганзориг/,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Энэ тогтоолыг Улс төрийн намын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

10.Улсын төрийн намын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Хуулийн төслийн талаар ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гаргаагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъянхүү, Монголын үндэсний бөхийн холбооны тэргүүн Ц.Магалжав, Монголын допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх захирал Д.Мөнхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжэе гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 01 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 13 цаг 34 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
11 цаг 33 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн байна. Хуралдааны ирц бүрдсэн учраас ТББХ-ны 23 оны 6 сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд байгаа. Хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгч 23 оны 4 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн. Өнөөдөр анхны хэлэлцүүлэг Байнгын хороогоор хийнэ. Байнгын хорооны тогтоол гарна. Чиглэл өгөх тухай тогтоол байгаа. Мөн бусад асуудлын хүрээнд хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, энэнтэй хамт Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг явуулна. Энэ хуулийн төслүүдийг Засгийн газраас 6 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлээд яаралтай дэгээр хэлэлцэж өгөөч гэсэн хүсэлт тавьсан байгаа. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Ажлын хэсгийн нэрсийг өгчихье. Ажлын хэсэг хаана байна вэ, оруулж байгаарай. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хуулийн бодлогын зөвлөх Бямбажаргал, СЕХ-ны Ажлын албаны дарга Баяндүүрэн, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Бундхорол, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор, доктор Мөнхсайхан, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн профессор Бумдарь, судлаач профессор, доктор Гэрэлт-Од, судлаач Энхцэцэг нарын хүмүүс ажлын хэсгийн бүрэлдэхүүнд байгаа, хүмүүсийг оруулахыг урья.

Чуулганы дэгийн тухай хуулийн 39.9-д хуулийн төсөлтэй холбогдуулж ажлын хэсэг байгуулсан бол тухайн Ажлын хэсэг хуулийн төслийн талаарх тусгайлсан саналаа танилцуулна гэж заасан байгаа. Их Хурлын даргын захирамжаар Тогтохсүрэн гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг гаргасан. Ажлын хэсэг, дэд хэсгүүд хуралдаад өнөөдөр Байнгын хороонд санал, дүгнэлтээ оруулж ирж байгаа. Тогтохсүрэн даргыг саналаа танилцуулахыг урьж байна.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг ТББХ 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа, Улсын Их Хурал 2023 оны 4 сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 99 дүгээр захирамжаар Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэнгээр ахлуулж Улсын Их Хурлын гишүүн Адъяасүрэн, Батжаргал, С.Ганбаатар, Ганболд, Доржханд, Мөнхцэцэг, Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Оюунчимэг, Сандаг-Очир, Туваан, Тэмүүлэн, Цогтгэрэл, Энхтүвшин нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд ажлын дэд хэсэг 8, ажлын хэсэг 2 удаа тус тус хуралдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.9 дэх хэсэгт хэрэв тухайн хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулсан бол тухайн Ажлын хэсэг хуулийн төслийн талаарх тусгайлсан саналаа эрхлэх асуудал нь хамаарах Байнгын хороонд танилцуулна гэж заасны дагуу Улсын Их Хурлын *Dparliament.mn* сайт цахим системд иргэдээс ирүүлсэн 52 санал, Ажлын хэсгийн гишүүн Адъяасүрэн, Батжаргал, Доржханд, С.Ганбаатар, Ц.Мөнхцэцэг нараас ирүүлсэн 63 санал, Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс ирүүлсэн саналууд болон 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулж улс төрийн 30 намын төлөөлөл оролцсон хуулийн төслийн хэлэлцүүлгээс гарсан саналуудыг үндэслэн Ажлын хэсэг дараах саналыг гаргаж, ТББХ-нд танилцуулж байна.

Улс төрийн намын хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар 44, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дээр 18, нийт 62 зарчмын зөрүүтэй саналын томъёолол мөн найруулгын 2 саналын томъёолол бэлтгэлээ. Түүнчлэн хууль хоорондын нийцлийг хангах зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Жендерийн эрх тэгш

байдлыг хангах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу эцсийн хэлэлцүүлгийн шатад шинээр боловсруулах шаардлагатай байна.

Мөн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр зохицуулах харилцааг Улсын дээд шүүхэд шилжүүлэх саналтай уялдуулан дээрх хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах санал боловсруулан танилцуулж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн гишүүнд баярлалаа. Чуулганы дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. 39.11-д төслийн тухайн зүйлтэй холбогдуулаад хууль санаачлагчаас болон ажлын хэсэг бусад оролцогчоос асууж асуулт асууж болно гэж заасан байгаа. Үүний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуулийнхаа төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Байнгын хорооны даргын зүгээс ажлын хэсгийн ахлагчид та хэрэв тухай тухайн саналууд дээр тодруулах зүйлүүд байвал шаардлагатай гэж үзвэл өөрөө хэлээд явчхаарай. Гишүүд асуухгүй бол яах вэ, тэгээд саналаа хураагаад ингээд явчихна.

Гишүүд танхимдаа орж ирэхийг урьж байна. Одоо хуулиа 1 дүгээр зүйл, 2 дугаар, зүйл бүрээр нь ингээд явна. Ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг тараасан

байгаа. Зүйл бүрээр ингээд хэлэлцээд явна. Гишүүдийг танхимдаа орж ирэхийг урья. Төрийн байгуулалтын байнгын хороо санал хураах гэж байна. Ирцэд бүртгэлд орсон гишүүд танхимдаа ирээрэй. Адьяасүрэн гишүүн, Сүхбаатар гишүүн, Амарсайхан гишүүн, Занданшатар гишүүн, Мөнх-Оргил гишүүн, Эрдэнэбат гишүүн. Ирэх байх, тийм байж байг. Сүхбаатар гишүүн, Амарсайхан гишүүн. Занданшатар дарга туслах руу нь. Мөнх-Оргил гишүүн.

Хуулийн төслүүдээ зүйл бүрээр хэлэлцэж эхэлнэ. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. 1 дүгээр зүйлийг хэлэлцлээ.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй байна.

3 дугаар зүйлээс эхлээд ажлын хэсгээс гарсан саналууд байгаа. Санал хурааж эхэлнэ. Танилцуулж байя. Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын гишүүн гэснийг 3.1.7 дахь заалтын биет ба биет бус хөрөнгө гэснийг 3.1.14 дэх заалтын шууд эсхүл шууд бус гэснийг болон 3.1.13 дахь заалтыг тус тус хасаж, 3.1.3 дахь заалтын сонгогдсон гэсний дараа томилогдсон гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Адьяасүрэн, Батжаргал, Ганбаатар, Ганболд, Доржханд, Мөнх-Оргил, Мөнхцэцэг, Оюунчимэг, Сандаг-Очир, Туваан, Тэмүүлэн, Цогтгэрэл, Энхтүвшин цаашид ажлын хэсэг гэнэ. 3 дугаар зүйлийн саяын танилцуулсан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын өдрийг гэснийг өдрөөс эхлэх жилийг гэж өөрчилж, 3.1.6, 3.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

3.1.6 Намын санхүүгийн тайлан гэж тайлант хугацаанд намаас энэ хуульд заасны дагуу гаргасан болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д заасан тайлангийн цахим болон хэвлэмэл мэдээллийн бүрдлийг.

3.1.8 төрийн санхүүжилт гэж нам чиг үүргээ хэрэгжүүлэхэд зориулж санхүүжилтийн зохих хэсэгт нь төрөөс мөнгөн хэлбэрээр олгож буй санхүүгийн дэмжлэгийг. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ. Амарсайхан сайдынх эсрэг гарчихсан байна шүү, таных, тийм анхаараарай. Тэгээд 3 дугаар санал. 3 дугаар зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

4 дүгээр зүйл. Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 4.2.2 дахь заалтын ард түмний гэснийг иргэдийн гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ. 4 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

5 дугаар зүйл. Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн болон тухайн намыг гэснийг хасаж, 5.9 дэх хэсгийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх гэсний дараа болон холбогдох бусад гэж нэмж, 5.10 дахь хэсгийн үзэл бодлоор гэснийг үзэл бодол, боловсрол зэргээр гэж, 5.13 дахь хэсгийн үүсгэн байгуулахад оролцохыг гэснийг үүсгэн байгуулах, гишүүнээр элсэхийг гэж тус тус өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ. 5 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

Төслийн 6 дугаар зүйлийг хэлэлцэнэ. Төслийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийн 24 жилийн гэснийг 12 жилийн гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.8 дахь хэсэг нэмэх.

6.8.Улсын дээд шүүхийн Тамгын газар намын нэрийн санг хөтөлж, лавлагаа олгоно. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжих санал хураалт явуулъя.

63,6 хувиар санал дэмжигдлээ. 6 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

7 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье санал хураалт. 63,6 хувиар санал хураалт, санал хураалтаар дэмжигдлээ. 7 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

8 дугаар зүйлийг хэлэлцье. Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн байгууллагын бүрэлдэхүүнийг сонгоход болон төрийн улс төрийн албан тушаалд намаас санал болгож сонгогдох, томилогдох нэр дэвшигчийг тодруулахад гэснийг байгууллагыг бүрдүүлэхдээ гэж өөрчилж, 8.2.3 дахь заалтын аль нэг хүйсийн гэсний өмнө нэр дэвшүүлэхдээ гэж нэмж, 8.8 дахь хэсгийг 8.8, 8.9 дэх хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах.

8.8. Жендерийн үндэсний хороо энэ хуулийн 8.2.3, 17.7-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг жил бүрийн 8 сарын 1-ний дотор Сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

8.9. Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 8.8-д заасан дүгнэлтийг үндэслэн зөрчлийг арилгах талаарх шаардлагыг тухайн намд хүргүүлэх бөгөөд хүргүүлсэн өдрөөс хойш 6 сарын дотор уг зөрчлийг арилгаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл төрийн санхүүжилтийг зогсооно гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье, санал хураалт. Ажлын хэсгийн гишүүд янз бүрийн юм яриад байх хэрэг байна уу даа. Саналаа хураачихъя. 54,5 хувиар санал дэмжигдлээ. 8 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

9 дүгээр зүйлийг хэлэлцье. Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн цахимаар явуулж болно. Ингэхдээ Сонгуулийн төв байгууллагаар баталгаажсан программ хангамжийг ашиглана гэснийг аюулгүй байдлыг хангасан программ хангамж ашиглан

намын дүрэмд заасны дагуу цахимаар явуулж болно гэж, 9.7 дахь хэсгийн Шилэн дансны тухай хуульд заасны дагуу гэж, Хувь хүний хуулиар хамгаалбал зохих мэдээллээс бусад мэдээллийг мэдээлнэ гэснийг энэ хуулийн 43.8-д заасныг баримтална гэж, 9.9 дэх заасны заалтын хэсгийн 9.6.1-ээс 9.6.7-д гэснийг 9.6.1, 9.6.3, 9.6.4, 9.6.5, 9.6.7, 9.6.8, 9.6.9, 9.6.10, 9.6.11, 9.6.12-т гэж, 9.10 дахь хэсгийн 9.6.1-ээс 9.6.7-д гэснийг 9.6.1-ээс 9.6.12-т гэж тус тус өөрчилж, 9.4 дэх хэсгийн цахим хуралдаан санал хураалтын үр дүнд гарсан шийдвэрийг хүчинтэйд тооцно гэсэн эхний өгүүлбэрийг хасаж, 9.6.9 дэх заалтын намын гэсний дараа болон харьяа байгууллагын гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.9 дэх заалт, 9.6.4 дэх заалт нэмэх.

9.6.4. Намын сонгуулийн мөрийн хөтөлбөр. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ. 9 дүгээр санал зүйлээр санал хурааж дууслаа.

10 дугаар зүйлээр санал хураалт явуулъя. Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын тусгаар тогтнол гэсний дараа бүрэн эрхт байдал гэж, 10.1.13 дахь заалтын гүйцэлдүүлэх гэсний дараа үйл ажиллагаа явуулах гэж тус тус нэмж, мөн зүйлийн 10.1.3 дахь заалтын үймээн самуун дэгдээх гэснийг хасаж, 10.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

10.1.4. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол зэргээр нь ялгаварлан гадуурхах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Асуулт Батсуурь гишүүний микрофоныг өгье.

Ж.Батсуурь: Энэ 10.1.6 сонгуульд нэр дэвших эрх олгохдоо намын гишүүн дэмжигчээсээ барьцаа, дэнчин болон бусад аливаа хэлбэрээр мөнгө болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ өгөхийг

шаардах, авах гэж байна. Бүх шатанд уу?
1 дүгээрт.

Н.Энхболд: Бүх шатанд.

Ж.Батсуурь: Шаардах, авах гэсэн нь юу гэсэн үг вэ? Авах гэдэг нь.

Н.Энхболд: Тогтохсүрэн дарга. Ер нь урьд нь практикт ийм зүйлүүд гарч байсан.

Ж.Батсуурь: Үгүй ээ үгүй. Тэгэхдээ энэ чинь.../үг тасрав/

Н.Энхболд: Шаардаж болохгүй, авч болохгүй л гэсэн үг байхгүй юу.

Ж.Батсуурь: Шаардах тийм авахыг хориглоно бүх шатанд.

Н.Энхболд: Бүх шатанд.

Ж.Батсуурь: Одоо тэгэхээр аль ч шатанд энэ багийн даргад чинь нөгөө нэг нэр дэвшихэд зардал юугаа энэ тэр гээд авдаг шүү дээ. Тэр энэ тэр бол бүр байхгүй гэсэн үг үү? Бүх шатанд байхгүй.

Н.Энхболд: Нэр дэвшихийн тулд мөнгө авахыг л хориглоно гэсэн үг бүх шатанд.

Ж.Батсуурь: Үйлчилгээ авахыг, тэгээд хөрөнгө авахыг хориглоно. Ойлголоо.

Н.Энхболд: Түрүүчийн явсан 9 дүгээр саналын дагуу санал хураалт явуулъя. Санал хураалт, санал хураалт гишүүдээ. 10 дугаар зүйлээр санал хурааж дууслаа. 63,6 хувиар сүүлийн санал дэмжигдэж байна.

Төслийн 11 дүгээр зүйл дээр саналтай, асуулттай гишүүн байна уу? Алга байна. 11 дүгээр зүйлээр хэлэлцэж дууслаа.

Төслийн 12 дугаар зүйл рүү оръё. Төслийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.5 дахь хэсгийн Сонгуулийн төв байгууллагад

гэснийг Улсын дээд шүүхэд гэж, 12.2 дахь хэсгийн Сонгуулийн төв байгууллагад гэснийг Улсын дээд шүүхийн гэж, 12.3.5 дахь заалтын хаягийн нотлох баримт гэснийг хаягийн мэдээлэл гэж тус тус өөрчилж, 12.3.7 дахь заалтын намын санхүүгийн асуудал гэсний өмнө намын дарга гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 12.6 дахь хэсэг нэмэх.

12.6.Энэ хуулийн 12.3.6, 12.3.7, 12.3.8-д заасан мэдээллийн маягтыг Улсын дээд шүүх батална. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдэж байна. 12 дугаар зүйлээр санал хураалт дууслаа.

13 дугаар зүйлээр санал хураалт явуулна. Төслийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.5 дахь хэсгийн Сонгуулийн төв байгууллага гэснийг Улсын дээд шүүх гэж, 13.6 дахь хэсгийн Сонгуулийн төв байгууллагад гэснийг Улсын дээд шүүхэд гэж тус тус өөрчилж, мөн хуулийн 13.4 дэх хэсгийг хасаж, доор дурдсан агуулгатай 13.5, 13.6 дахь хэсэг нэмэх.

13.5.Улсын дээд шүүх намын нэр энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн эсэхийг нягтлан шалгахдаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.1.5, энэ хуулийн 6.8-д заасан нэрийн санг ашиглана.

13.6.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 13.5-д заасан Нэрийн санг ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ гэж ажлын хэсэгчээс гаргасан саналыг дэмжье. Санал хураалт. Батсуурь гишүүн. Батсуурь гишүүний микрофоныг өгье.

Ж.Батсуурь: Би нөгөө бүгдийг уншиж амжихгүй нөгөө санал хураалтад яах гээд байна л даа. Нөгөө энэ бүртгэлтэй холбоотой асуудал чинь ер нь нөгөө Дээд шүүхийн юугаар хуучнаараа байгаа юу? Сонгуулийн хороонд хамаарч байна уу, Улсын бүртгэлд хамаарч байна

уу, Дээд шүүхэд хамаарч байна уу? Тодорхой хариулт.

Н.Энхболд: Дээд шүүх. Ажлын хэсэг Тогтохсүрэн дарга.

Ж.Батсуурь: Яагаад вэ гэхээр нөгөө өнгөрсөн 3 жилийн будилаан маань энд ер нь манай намын энэ алдаа бусад юунууд дээр бас давтагдах вий. Тэр яг нөхцөл байдал бол бас бие, бие рүүгээ чихээд, маш хэцүү нөхцөл байдлууд үүсэж байсан байхгүй юу. Дээд шүүх нь Улсын бүртгэл рүү, Улсын бүртгэл нь Сонгуулийн хороо руу, тэгээд л одоо тэглээ ингэлээ гээд байсан энэ нөхцөл хэр цэгцэрсэн бэ? Би нөгөө бүгдийг нь харж амжсангүй болохоор.

Н.Энхболд: Тийм ээ тийм. Асууж байсан нь бас зөв. Тогтохсүрэн гишүүн хариулъя.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Хуулийн төслийг хууль санаачлагч өргөн барихдаа СЕХ бүрдүүлбэрийг бий болгож, хянаад, нам байгуулах хүсэлтийг хүлээж аваад, СЕХ хүлээж аваад, бүрдүүлбэрийг нь СЕХ хянаад ингээд Улсын дээд шүүхэд хүргүүлж, Улсын дээд шүүх нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэж шийдэх ийм зохицуулалт орж ирсэн юм. Энийг бид нар улс төрийн намуудынх нь саналыг сонсож байгаад ажлын дэд хэсэг дээрээ ярилцаж байгаад, тэгээд ажлын хэсэг юу гэж шийдсэн бэ гэхээр бүртгэлтэй холбоотой, анхны бүртгэлтэй холбоотой, бүртгэл өөрчлөлттэй холбоотой асуудлыг бол цэвэр 100 хувь Улсын дээд шүүх хариуцна. Сонгуулийн хороо бол энд оролцохгүй. Сонгуулийн хороогоор дамжихгүй, цэвэр 100 хувь Улсын дээд шүүх хариуцахаар орж өгсөн байгаа.

Өөрөөр хэлбэл юугаар бол дамжихгүй гэсэн үг. Сонгуулийн хороогоор. Улсын бүртгэлээр дамжихгүй, материал 100 хувь Дээд шүүх дээр очно. Өмнө нь байсан зарим нэгэн ойлгомжгүй эд нар асуудлуудыг энэ Шүүхийн тухай хууль болон Дээд шүүхийн чиг үүрэгт нь

нэлээд тодорхой болгоод оруулаад өгчихсөн байгаа. Тийм учраас одоо бол бүртгэлтэй холбоотой асуудал бол 100 хувь Дээд шүүхийн асуудал байгаа.

Н.Энхболд: Тодруулъя. Батсуурь гишүүн, Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Сая та шинээр нам байгуулах талаар ярьчих шиг боллоо. Одоо ингээд үйл ажиллагаагаа олон жил явуулж байсан намууд хурлаа хийгээд нөгөө дүрмээ бүртгүүлэхээр өгдөг шүү дээ. Тэрний нөгөө хоног хугацааг маш тодорхой зааж, нөгөө нэг процессын асуудлуудыг энэ дээр хэр орсон бэ? Тэгэхгүй бол ингээд юу яадаг хурлаа хийгээд дүрмээ өгчихдөг, дүрмийг нь баталдаггүй, бүртгэдэггүй. Тэгээд тэр цонхон дээр хоосон байна, энэ цонхон дээр бүртгэлгүй байна гээд ингээд байдаг. Ахиад лавлагаа авах болохоор Дээд шүүх авах ёстой, Тамгын газар нь өгөх ёсгүй энэ тэр гээд ингээд маш олон эргэлзээтэй зүйлүүдийг түрүүн хуульд байсан. Тэгээд энэнээс болж бас нэлээд л будилаан гарч байсан. Тэгээд энэ ер нь хэр тодорхой болсон бэ? Та бол сая тайлбар хийхдээ шинээр бүртгэгдэх намын тухай ярилаа. Хуучин үйл ажиллагаа явуулж байгаа намууд Их хурлаараа дүрэм.../минут дуусав/

Н.Энхболд: Тогтохсүрэн дарга хариулъя.

Д.Тогтохсүрэн: Энд шинээр бүртгэх, мөрийн хөтөлбөр, дүрэмд өөрчлөлт оруулах, нэр өөрчлөлт орох гээд бүх л өөрчлөлтүүд бүгдээрээ Дээд шүүх дээр явна. Дээд шүүхийг бас яг тодорхой, тодорхой хугацаатай болгоод өгчихсөн. Тухайлбал та 13 дугаар зүйлийн 1-ийгээ уншаарай. Улсын дээд шүүх нь намыг бүртгүүлэх өргөдлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор өргөдөл хүсэлтийг хянан шалгана гэж байгаа юм, нягтлан шалгана. Дээд шүүх нь өргөдөл хүсэлтийг хүлээн авснаас хойш зөрчил илрүүлбэл 30 хоногийн дотор уг зөрчлийг арилгана гээд бүх процессуудыг ингээд бичээд өгчихсөн. Бүгдийг нь тэр 13, 14

дүгээр заалтууд дээр хуулийнх нь бүх юмнуудыг явуулаад, хамгийн сүүлд 13.7 дээр Улсын дээд шүүх. Хойшоогоо байгаа. Ингээд хийгээд өгсөн. Нарийвчилсан тайлбарыг манайхнаас нэг нь хийгээд өгчих юм уу? Яг процесс.

Н.Энхболд: Ажлын хэсгээс Мөнхсайхан багш нэмж тайлбарлая. 4 дүгээр микрофон өгчхөөрэй.

О.Мөнхсайхан: Баярлалаа. Батсуурь гишүүний яг асуусан асуултын зохицуулалт 15.3, 15.4 дээр байгаа юм. Өөрөөр хэлбэл байгаа намын дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт, даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд Шүүхэд хүргүүлнэ. Дээд шүүхийн Тамгын газар энэ шийдвэрт үндэслээд нийтэд мэдээлж, Сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ гээд орчихсон байгаа. 15.3, 15.4. 3, 4.

Н.Энхболд: Хойшоо дараагийн зүйлүүд дээр гарна. Энэ зүйл дээр бол Батсуурь гишүүнээ 13.7 дээр жишээ нь байж байгаа. Энд байгаа. Дугаар нь өөрчлөгдчихсөн тийм. Тэр сүүлд өгсөн материалаа Батсуурь гишүүнд өгөөрэй. Саяын унишиж танилцуулсан томьёоллоор гаргасан ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. Санал хураалт Батсуурь гишүүнээ. Батсуурь гишүүнээ санал. 63,6 хувиар санал дэмжигдлээ. 13 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

14 дүгээр зүйлийг хэлэлцэнэ. Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн Сонгуулийн төв байгууллага гэснийг Улсын дээд шүүхийн Тамгын газар гэж, 14.4 дэх хэсгийн улсын бүртгэлд гэснийг намын бүртгэлд гэж, 14.9 дэх хэсгийн Сонгуулийн төв байгууллага гэснийг Улсын дээд шүүх гэж тус тус өөрчилж, 14.3 дахь хэсгийн гэрчилгээ гэсний дараа тамга тэмдгийн хяналтын дугаар гэж, 14.6 дахь хэсгийн Сонгуулийн төв байгууллага гэсний дараа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэж, баримт бичиг гэсний

дараа лавлагаа гэж тус тус нэмж, мөн зүйлийн 14.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

14.1.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар энэ хуулийн 13.1, 13.2-т заасан хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн тухайн намыг намын бүртгэлд бүртгэх эсхүл бүртгэхээс татгалзах тухай шийдвэр гаргаж, Улсын дээд шүүхийн Тамгын газар ажлын 3 өдрийн дотор өргөдөл гаргагчид бичгээр болон цахимаар хүргүүлж нийтэд мэдээлнэ. Ажлын хэсгийн саналыг дэмжье. 72,7 хувиар санал дэмжигдэж байна.

Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.7, 14.11 дэх хэсэг тус тус нэмэх.

14.7.Энэ хуулийн 12.2, 12.3, 12.4, 15.3, 21.1, 21.4-т заасан болон бусад мэдээлэл, баримт бичиг, түүнд оруулсан өөрчлөлтийг холбогдох байгууллагад хүргүүлэх журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Сонгуулийн төв байгууллагын дарга хамтран батална.

14.11.Намыг бүртгэхтэй холбоотой журмыг Сонгуулийн төв байгууллага Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан энэ хууль болон бусад хуульд нийцүүлэн Улсын дээд шүүх батална. Саналыг дэмжье. Ажлын хэсгийн санал. 63,6 хувиар санал дэмжигдлээ. 14 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

15 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

Улсын дээд шүүхийн Тамгын газар энэ хуулийн 15.3-д заасан шийдвэртэй холбоотой мэдээллийг бүртгэж, энэ тухай нийтэд мэдээлж, Сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье. Батсуурь гишүүн асууя. Энэ санал хүчингүй шүү. Батсуурь

гишүүний микрофоныг өгье. Батсуурь гишүүний микрофон.

Ж.Батсуурь: Энэ 5 дугаар бүлэг дээр намын бүтэц, зохион байгуулалт гээд. Энэ намын өөрийнх нь дээд шатны шийдвэр гарчхаад байхад заавал 60 хоног гэдэг нь ямар учиртай юм бол? Удирдах байгууллагын энэ чинь сонгууль тулсан үед.../үг тасрав/

Н.Энхболд: Аль заалтыг яриад байна вэ?

Ж.Батсуурь: Тийм, ахиад 15.4 дээр ч байж байна. Энэ чинь бол аль ч намд юутай. Жишээлбэл хэзээ ч тухайн нам шийдвэрээ гаргаж болно шүү дээ. Тухайн удирдах дээд байгууллага нь тухайн нам бүрэн бүрэлдэхүүнээрээ шийдвэрээ гаргачхаад байхад тэрийг 60 хоног гэж ингэж арагш нь тавих, үгүй ээ тэгээд яахаараа 60 байх вэ? Тэгээд заавал 60. Үгүй ээ заавал 60 байдаг нь харин ямар учиртай юм бэ? Тийм. Тэгээд хүн өөрөө шийдвэрээ гаргачхаад байхад чинь. Тэгээд яадаг вэ гэхээр ингэдэг байхгүй юу. Бодит байдал дээр хугацаандаа хугацаа нь болоогүй байна, хуульд заасан хугацаа нь болоогүй байна гээд ингээд хойш нь тавиад байдаг байхгүй юу.

Жишээ нь сонгууль болох гэж байя гэж бодъё. Сонгуулийн өмнө хуралдаад тухайн нам шийдвэрээ гаргачхаад байхад сонгууль хүртэл тэрийг тухайн намын шийдвэрийг бүртгэхгүйгээр хойш нь татах ийм боломж Дээд шүүхэд бий болгож өгч байгаа байхгүй юу.

Н.Энхболд: Үгүй ээ ер нь хүртэл гэсэн заалт бүх л хуулийн заалтууд дээр тийм тайлбарууд хийж болно л доо.

Ж.Батсуурь: Үгүй ээ тэгэхдээ цаад талын хугацаа тийм урт байх ямар ч шаардлага байхгүй.

Н.Энхболд: Хариулъя.

Ж.Батсуурь: Тухайн намын энэ шийдвэр болохоос тэрийг бүртгэх хүн

заавал тэрийг хугацааг зааж өгч байх хэрэг байхгүй.

Н.Энхболд: Тогтохсүрэн дарга ажлын хэсгийн ахлагч.

Д.Тогтохсүрэн: Энэ нам дүрэмдээ өөрчлөлт оруулсан л бол тэр дүрмийн өөрчлөлт болон намын даргыг шинээр томилогдсонтой холбоотой заалтыг тухайн нам өөрөө 60 хоногийн дотор л хүргүүлнэ гэж байгаа юм. Тэгэхээр нэг өдрийн дотор ч хүргүүлж болно. 60 хоног гэдэг нь хамгийн дээд хугацааг зааж өгч байгаа юм.

Бүртгэлийг, бүртгэлийг шүүх 30 хоногийн дотор гаргана гэхчхэн байгаа. Бүртгэлийг энэ өөрчлөлтийн бүртгэлийг шүүх 30 хоногийн дотор гаргана гэж. Тэгэхээр 60 хоногийн дотор гэдэг хугацаа бол нэг хоногийн дотор ч болно, 60 хоногийн дотор ч болно. Тухайн нам л өөрөө л шийднэ. Шүүх дээр ирснээс хойш, ирснээс өргөдөл хүсэлт нь шүүх дээр ирснээс хойш шүүх 30 хоногийн дотор шийднэ л гэдэг л ийм л асуудал зохицуулж өгч байгаа юм. Хамгийн гол юм нь бид нар шүүх дээр хянагдах хугацааг л шүүхийн эцсийн шийдвэр гарах хугацааг л зааж өгсөн байгаа.

Н.Энхболд: Тэгээд яах вэ 15 болгочихвол яагаад 15 юм бол, нэгэнд нь шийдчихсэн байхад маргааш нь л баталж өгөх ёстой шүү дээ гэсэн юм тавих гээд байна л даа. Тэгэхдээ, үгүй ээ янз бүрийн л тохиолдлууд гардаг шүү дээ. Нөгөө нам, дотоод нам дотооддоо жишээ нь дотоод дүрмээ юм уу, өөрийнхөө журмыг зөрчөөд ийм юм хийчихлээ гээд араас нь жишээ нь гомдол ирвэл яах вэ тийм ээ гэх мэтчилэн. Тэгвэл тэр чинь шүүхэд бас нэг хянах, нотлох ийм хугацаа хэрэгтэй л болно шүү дээ. Түүнээс заавал 30 хоног хүлээ гэсэн үг биш. Асуудалгүй бол тэгээд л аль болохоор л хурдан шүү дээ. Бүх л хуулиуд дээр ийм заалт байгаа шүү дээ Батсуурь гишүүн. Яах вэ хэрэв ингэнэ Батсуурь гишүүнээ та хоёр микрофонгүй яриад байна.

Хугацаа их байна гэж үзэж байгаа бол та санал гаргаж болно. Нэг хоногийн дотор ч гэдэг юм уу эсхүл шууд та өөрийн чинь хэлж байгаагаар нэгэнт намын төв байгууллага шийдсэн байхад тэрийг бушуухан л баталж өгөх ёстой гэж байна шүү дээ. Хянах, шалгах шаардлага бараг байхгүй шахуу юм ярих гээд байна шүү дээ. Ойлголоо таны юу тийм. Хэрэв та зөвшөөрөхгүй бол зарчмын зөрүүтэй өөр санал гаргаж болно. Юу ч гэсэн одоо энүүгээрээ саналаа хураачихъя. Тэгээд дэмжигдвэл цаашаа үргэлжлээд явъя. Санал хураалт. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Саналаа, саналаа Тогтохсүрэн дарга. 54,5 хувиар санал дэмжигдлээ. 15 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

16 дугаар зүйл дээр саналтай асуулттай гишүүн байна уу? Байхгүй байна.

Төслийн 17 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 17.2.2 дахь заалтын жил тутам гэснийг жилийн хугацаанд гэж, 17.2.2 дахь заалтын болон гэснийг бүрэлдэхүүнийг 4 жилээс илүүгүй хугацаагаар сонгох эсхүл батламжлах гэж тус тус өөрчилж, 17.3 дахь хэсгийн намын дүрэмд заасан тохиолдолд гэснийг хасаж, мөн доор мөн зүйл доор дурдсан агуулгатай 17.4 дэх хэсэг нэмэх.

17.4.Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн 2/3-оос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн дүрмийн 1/3-ээс хэтрэхгүй байна гэсэн санал ажлын хэсгээс гаргасныг дэмжье. 17 дугаар зүйл. Санал хураалт. 17.4 дэх заалт ярьж байна. 63,6 хувиар санал дэмжигдлээ. 17 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

18 дугаар зүйл дээр саналтай гишүүн, асуулттай гишүүн байна уу? Алга байна.

19 дүгээр зүйлээ хэлэлцэж эхэлье. Төслийн 19 дүгээр зүйл доор дурдсан агуулгатай 19.4, 19.5, 19.6 дахь хэсэг тус тус нэмэх.

19.4.Нам бүх шатны сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгон шалгаруулах хороотой байх бөгөөд хорооны бүрэлдэхүүнд тавих шаардлага, тавигдах шаардлага, түүнийг байгуулах, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах болон үйл ажиллагааны журмыг энэ хуулийн 8 дугаар зүйл, намын дүрэмд нийцүүлнэ.

19.5.Энэ хуулийн 19.4-д заасан хороо нь нэр дэвшигчийг сонгон шалгаруулахдаа энэ хуулийн 8.2.1, 8.2.2, 8.3-д заасныг баримталж, тухайн албан тушаалыг хаших ёс зүйн болон хууль тогтоомж холбогдох журмаар тогтоосон бусад шаардлагад үндэслэнэ.

19.5.Энэ хуулийн 19.4, 19.5-д заасан журмыг намын төлөөллийн төв байгууллага нь батална. Батсуурь гишүүн. Батсуурь гишүүний микрофоныг өгье.

Ж.Батсуурь: Энэ нөгөө намын бусад байгууллага гэж байна. Тэгэхээр нөгөө намын дэргэдэх байгууллагууд энэ хуульд ер нь яаж орж байгаа вэ? Нөгөө намууд чинь дэргэдээ Ахмадын холбоо, Эмэгтэйчүүдийн холбоо, Залуучуудын холбоо, Оюутны холбоо гээд л ингээд байж байна шүү дээ. Байхаар орж байгаа юу, байхгүйгээр орж байгаа юу? Тэгэхдээ энэ дотор бол заалт байхгүй байна шүү дээ. Намын бусад байгууллага гэдэгт орохгүй юу? 3.1-ийн. Байх юм байна, тийм ээ? За.

Н.Энхболд: Санал хураалт. Байнгын, ажлын хэсгээс гаргасан санал саяын энэ томьёоллыг дэмжье гэсэн санал хураалт явуулна. 63,6 хувиар санал дэмжигдэж байна. 16 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

17 дугаар зүйлд орё. Төслийн, 20 дугаар зүйл. 20 дугаар зүйл. Сая 19-өөр

дууссан шүү. 20 дугаар зүйл. Төслийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжих санал хураалт явуулъя. 72,7 хувиар санал дэмжигдлээ. 20 дугаар зүйлээр санал хурааж дууссан.

21 дүгээр зүйлээр санал хураалт явуулъя. Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн төрийн санхүүжилтийг зогсоох бөгөөд гэсний дараа зөрчлийг арилгах хүртэл гэж, 21.4 дэх хэсгийн Сонгуулийн төв байгууллага гэсний дараа Улсын дээд шүүхэд хүргүүлэх бөгөөд Улсын дээд шүүх гэж, 21.5 дахь хэсгийн дуусах хүртэл намыг гэсний дараа идэвхтэй эсхүл гэж тус тус нэмж, 21.5 дахь хэсгийн Сонгуулийн төв байгууллага гэснийг Улсын дээд шүүх гэж өөрчилж, 21.6 дахь хэсгийг хасаж, 21.1, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

21.1.Улсын дээд шүүх Сонгуулийн төв байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн дараах тохиолдолд намыг идэвхгүйд тооцох тухай шийдвэрийг гаргана.

21.3.Энэ хуулийн 21.1-д заасан зөрчил гаргасан намын эрх бүхий байгууллага сонгуульд оролцох шийдвэр гаргавал Сонгуулийн төв байгууллагад бүртгүүлсэн эсхүл энэ хуулийн 21.1.2, 21.1.3-д заасан зөрчлөө арилгасан талаар холбогдох нотлох баримтыг Сонгуулийн төв байгууллагад албан ёсоор хүргүүлнэ гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжих санал хураалт явуулъя. 72,7 хувиар дэмжигдэж байна.

Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 21.6 дахь хэсэг нэмэх.

21.6.Энэ зүйлд заасны дагуу гаргасан Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна. Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдэж байна. 21 дүгээр зүйлээр санал хураалт явж дууслаа.

22 дугаар зүйл рүү оръё. Төслийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн хуульд өөрөөр заагаагүй бол гэсний дараа Сонгуулийн төв байгууллага гэж нэмж, 22.2 дахь хэсгийг 22.2, 22.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах.

22.2.Улсын дээд шүүх энэ хуулийн 23.1, 24.1-д заасан шийдвэрийг хүлээн авснаас эсхүл 25.3-д заасан шийдвэрийг гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор тухайн намыг бүртгэлээс хасаж, гэрчилгээ, тамга тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгоно.

22.3.Улсын дээд шүүхийн Тамгын газар энэ хуульд заасны дагуу намыг татан буулгасан тухай шийдвэр шаардлагатай бусад мэдээллийг Сонгуулийн төв байгууллага болон бусад этгээдэд хүргүүлж нийтэд мэдээлнэ. Ажлын хэсгийн саналыг дэмжъё. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдэж байна. 22 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

23 дугаар зүйл. Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн Сонгуулийн төв байгууллагад гэснийг Улсын дээд шүүхэд гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжъё. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ. 23 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

24 дүгээр зүйл. 24 дүгээр зүйлийн. Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн Сонгуулийн төв байгууллагад гэснийг Улсын дээд шүүхэд гэж өөрчилж, 24.2 дахь хэсгийг 24.2, 24.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах.

24.2.Энэ хуулийн 22.2-т заасны дагуу шийдвэр гарсан бол татан буулгах комисс намын өр төлбөрийг барагдуулж дууссаны дараа үлдсэн хөрөнгийг Сонгуулийн төв байгууллагад шилжүүлнэ.

24.3.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 24.2-т заасны дагуу шилжүүлсэн хөрөнгийг иргэдийн улс

төрийн боловсролыг дээшлүүлэхэд зарцуулна. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдэж байна. 24 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

25 дугаар зүйл. Төслийн 25 дугаар зүйлийн 25.2, 25.3 дахь хэсгийн дүгнэлтийг гэснийг саналыг гэж өөрчилж, 25.3 дахь хэсгийн шийдвэр гаргаж, гэсний дараа Улсын дээд шүүхийн Тамгын газар гэж нэмж, шийдвэр гаргаж гээд таслалтай шүү. Тэгээд Улсын дээд шүүхийн Тамгын газар гэж нэмж мөн зүйлийн 25.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

Энэ хуулийн, 25.1.Энэ хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3-д заасан хориглолтыг зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн бол Сонгуулийн төв байгууллага намыг тараах тухай үндэслэл бүхий санал гаргаж, холбогдох нотлох баримт, хуралдааны тэмдэглэлийн хамт Улсын дээд шүүхэд хүргүүлнэ. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 63,6 хувиар санал дэмжигдэж байна. 25 дугаар зүйл дээр санал хурааж дууслаа.

26 дугаар зүйл. Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.5 дахь заалтын энэ хуулийн 36.3-д заасан гэснийг энэ хуулиар зөвшөөрсөн гэж, 26.4 дэх хэсгийн үйл ажиллагааг санхүүжүүлэх замаар гэснийг үйл ажиллагаанд гэж, 26.8 дахь хэсгийн цахим мөнгөн хэрэгсэл хаалт дотор крипто валют, NFT зэрэг, энэ заавал энэ энийгээ өөрчилж ойлгомжтой томъёолоорой. Хаалтад ...-ээр гэснийг цахим мөнгөөр гэж тус тус өөрчилж, 26.6 дахь хэсгийн зарцуулсан бол гэсний дараа Сонгуулийн төв байгууллага гэж, 26.7 дахь хэсгийн хүлээн авах бөгөөд өөр гэсний дараа харилцах гэж тус тус нэмж, 26.7 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ. 26 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

27 дугаар зүйл. 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн 05 хувиар гэснийг 07 хувиар гэж, 27.3 дахь хэсэг, 27.6.1 дэх заалтын 2-оос гэснийг 1 ба түүнээс гэж, 27.6.5 дахь заалтын 50 дахин гэснийг 25 дахин гэж, 27.9 дэх хэсгийн 36.3.1-ээс 36.3.3-д гэснийг 36.3.1-ээс 36.3.4-д гэж тус тус өөрчилж, 27.11 дэх хэсгийн нам тарах гэснийг болон мөн зүйлийн 27.8 дахь хэсгийг тус тус хасаж, доор дурдсан агуулгатай 27.10, 27.12, 27.13 дахь хэсэг тус тус нэмэх.

27.10.Эвслийн гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн хаалт дотор C1 унших юм уу юу гэж? C1, T1 хэсгийг эвсэлд нэгдсэн хаалтаа хаагаад хэсгийг эвсэлд нэгдсэн намуудад тэнцүү хувааж, төрийн санхүүжилтийн C2, T2 хэсгийг тухайн суудалд сонгогдсон гишүүнийг нэр дэвшүүлсэн намд олгоно.

27.12.Намд олгох төрийн санхүүжилтийг жил бүр Сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад суулгаж батлуулна.

27.13.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг Сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу намын төв байгууллагад олгох бөгөөд салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг намын дүрмээр зохицуулна. Санал гаргасан ажлын хэсэг. Батсуурь гишүүн. Батсуурь гишүүний микрофоныг өгье.

Ж.Батсуурь: 2 асуулт байна. Энэ 1 сарын хөдөлмөрийн хөлсний 05-аар сонгуулиар сонгогчдын нэрсийн жагсаалт бүртгэсэн гэж. Энэ төсөв дээр хэдэн төгрөг суух вэ гэсэн дүн нь 1 дүгээр асуулт.

2-т гэвэл энэ хуваарилалттай холбоотой нөгөө Улсын Их Хурлын гишүүдийн суудлын тоогоор өгдөг мөнгө энэтэй давхардах уу? Нэгдсэн байдлаар орж байгаа юу гэсэн 2 асуулт.

Н.Энхболд: Тийм. Бүгдээрээ нэгдсэн дүнгээр эцсийн дүндээ гарах ёстой. Тогтохсүрэн дарга хариулт өгье.

Д.Тогтохсүрэн: Улс төрийн намд өгөх төрийн санхүүгийн дэмжлэг 2 чиглэлтэй байна. Нэг дэх нь сонгуульд авсан саналаараа авна, саналаараа авна. Өмнө нь нэг санал бол 1000 төгрөг байсан. Одоо 3850 төгрөг болж байгаа.

2 дахь нь энэ мөнгөн дүнг бид нар хууль санаачлагчаас өргөн барьсан мөнгөн дүнг тодорхой хүрээнд багасгасан. Тэр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 байсныг 25 болгосон гээд бид нар аль болохоор юу орж ирснээс нь нэлээд хэмжээгээр багасгасан. Нийт дүнгээрээ хамгийн максимум 8.2, 3 орчим болох юм байна лээ. Жил жилийнх нь. Одоо бол улсын хэмжээнд 4,9 орчим байдаг юм байна лээ дээд тал нь. Тийм. Тэгэхээр 4 орчмоор нэмэгдсэн байна л гэж. Хоёулаа орно. Би сая хэлчихлээ шүү дээ. Нэг нь саналаар авсан дүн. Нэг нь 2 дахь санхүүжилт нь Улсын Их Хурлын гишүүнд Улсын Их Хуралд суудал авсан намд суудлынх нь тоогоор санхүүжилт гэсэн 2 санхүүжилт байгаа. Би нэгийг нь хэлээгүй юм байна. Уучлаарай. Энэ 2 нийлээд 8,3 орчим болох юм байна гэж тооцож байгаа. Хамгийн максимум нь. Энэ чинь дотроо бол багасгах.../үг тасрав/

Н.Энхболд: Үүнийг нь намын төв байгууллагад нь ишлжүүлээд, төв байгууллага нь өөрийнхөө дүрмийн дагуу хуваарилаад, ашиглаад явах хуульд орж байгаа. Оюунчимэг. Оюунчимэг гишүүн асуулт асууя.

М.Оюунчимэг: Би өчигдөр уг нь ажлын хэсгийн хурал дээр энэ санал гаргах гэж байгаад нөгөө хоцроод ороод ирсэн. Нийгмийн бодлогын байнгын хороон дээр Нийгмийн даатгалын багц хуулиар санал хураалт явагдаж байгаатай давхцаад. Энэ бусад улс орны Улс төрийн намын тухай хууль дээр, Сонгуулийн хууль дээр ч ингээж тусгачихсан байдаг. Бид нар нөгөө нэг

хүйсийн тэгш байдлыг хангах гээд яриад байгаатай уялдаад энэ жендерийн эмэгтэйг сонгогдсон гишүүд, хөгжлийн бэрхиээлтэй гишүүд ч юм уу, энэ сонгогдсон тохиолдолд бас санхүүгийн дэмжлэг үзүүлэх заалтуудыг яг бүүр тусгаад өгчихсөн байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ 27.6 дээр уг нь энэ заалтыг ингээд тусгаад өгчихвөл зүгээр байх юм. Сонгогдсон эмэгтэй, хөгжлийн бэрхиээлтэй гишүүнийг татуулахгүйн тулд тухайн жилд сонгогдсон эмэгтэй болоод хөгжлийн бэрхиээлтэй гишүүн нэмэлт санхүүжилт олгохтой холбоотой асуудал байгаа. Энийг тооцоод үзэхэд 25 юм уу, 26 гишүүн сонгогдлоо гээд үзэхэд 13, жилд 13 сая 700 мянга гээд, жилийнх нь 300 сая орчим л төгрөгийн асуудалд тусах юм байна лээ. Зүгээр дунджаар тооцоо бодоод үзэхэд. Тэгээд энийг уг нь 27.6 дээр тусгаад өгчихвөл их зүгээр байна даргаа. Санал гаргаад. Үгүй ээ энэ байдаг юм уу.../үг тасрав/

Н.Энхболд: Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Тэр саяын Оюунчимэг гишүүний хэлжэ байгаа, байгаа байгаа. Ийм байгаа. Намууд бол би түрүүн хэлчихсэн. Нэг дэх юм нь бол нөгөө авсан саналаараа санхүүжилт авна. 2 дахь нь Улсын Их Хуралд авсан суудлаараа санхүүжилт авна. 3 дахь нь саяын хэлсэн квотоосоо илүү эмэгтэй нэр дэвшүүлсэн, хөгжлийн бэрхиээлтэй иргэн нэр дэвшүүлсэн тохиолдолд бас энэ дээр бодогдчихсон байгаа. Бас нэмэлт санхүүжилт авна, илүүгээрээ авна. 27.7 дээр байгаа 27.7 тэрийг уншаарай. Оюунчимэг гишүүн. 27.7 дээр.

Н.Энхболд: 27.7-г нь би уншаад өгчихье.

Д.Тогтохсүрэн: Үгүй авснаараа суудлаараа авна, суудлаараа авна.

Н.Энхболд: Суудлаараа авна, нөгөө санал авснаараа авна. Энэ дотроо 27.7 дээр Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-д заасан шалгуурууд заасан шаардлагыг хангасан намд Улсын Их

Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсээс, хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог энэ хуулийн 27.6.5-д заасан дүнгээр үржүүлсэнтэй тэнцэх төрийн санхүүжилтийг тухайн ээлжит сонгуулийн дараагийн жил нэг удаа олгоно гэсэн ийм заалт байгаа. Санал хураалт. Тийм. Тэгэхдээ харгалзаж үзэж байна л гэсэн үг шүү дээ тэр чинь. Тийм. Саналаа. Урамишуулж. 63,6 хувиар санал дэмжигдлээ. 27 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

28 дугаар зүйл. Төслийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн энэ хуулийн 28.1-д заасан гэснийг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ гэж, 30 хоногийн дотор гэснийг долоо хоногийн гэж, 28.2 дахь хэсгийн гаргасан гэснийг баталсан гэж тус тус өөрчлөх ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдэж байна. 28 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

29 дүгээр зүйл. Төслийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн 2 удаа гэснийг, 29.5 дахь хэсгийн суурь гэснийг, 29.10 дахь хэсгийн давж гэснийг тус тус хасаж, 29.4 дэх хэсгийн нягтлан шалгах ажиллагаа явуулж байгаа бол үйл ажиллагаа, уул ажиллагаа дууссаны дараа гэснийг хянасны дараа гэж, 29.5 дахь хэсгийн төрийн санхүүжилт авах намын эрх үүссэн жилийн 12 сарын 31-ний өдрөөс гэснийг төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилээс гэж, 29.6 дахь хэсгийн энэ хуулийн 27.5-д заасны дагуу тухайн намын авсан хүчинтэй саналын тоо /С1/ тоонд суурилсан төрийн санхүүжилтийн хэсгийг гэснийг энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн /С1, Т1/ хэсгийг дараагийн жилд гэж, 29.7 дахь хэсгийн тайлангийн агуулга алдаа зөрчилтэй эсэхээс үл хамааран тайлангаа гэснийг санхүүгийн тайлангаа гэж, тэмдэглэлийн гэснийг дүгнэлтийн гэж, 29.9 дэх хэсгийн нийтлэгдсэн гэснийг тусгасан гэж, 31.3.1-ээс 31.3.3-д заасан гэснийг 31.3.1-ээс, 36.3.1-ээс 36.3.4-д гэж тус тус

өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдэж байна. 29 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

30 дугаар зүйл. Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн нэг хувиас доошгүй гэснийг нэг ба түүнээс дээш хувийн гэж, 30.1.1 дэх заалтын зохион байгуулахад гэснийг зохион байгуулах, иргэдийг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх зорилгоор гэж, 30.1.2 дахь заалтын телевизээр жилд гэснийг телевизээс гаргасан гэж тус тус өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 30 дугаар зүйлээр санал хурааж, санал 72,7 хувиар дэмжигдлээ. 30 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

31 дүгээр зүйл. Төслийн 31 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

31 дүгээр зүйл. Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт тавих хяналт.

31.1. Сонгуулийн төв байгууллага төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг түүний зарцуулалтын тайланг хянаж, хүлээн авч нэгтгэн тайлагнана.

31.2. Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу намын санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээдээр хараат бусаар дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавина.

31.3. Төрийн аудитын байгууллага нь сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад туссан намд олгох төрийн санхүүжилт, түүний зарцуулалт, тайлагналт, төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу аудит хийж, дүгнэлт гаргана. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулна. Энэ чинь эхний заалт нь намууд. Эхний заалт чинь нөгөө заавал төрийн бус биш, ерөөсөө эрх бүхий төрийн аудитын, аудитын байгууллагаар гэсэн. Тийм. Тэр нь 31.2-оороо. Нөгөөдөх нь 3-аараа явж байгаа. Тийм ээ, тийм. Санал хураалт. 72,7 хувиар санал

дэмжигдлээ. 31 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

32 дугаар зүйл дээр саналтай, асуулттай гишүүн байна уу? Алга байна.

33 дугаар зүйл. 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн намын дансаар гэснийг зөвхөн данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр намын дансанд гэж, тооцооны гэснийг харилцах гэж тус тус өөрчилж, 33.4 дэх хэсгийн үнэлэн бүртгэж гэснийг болон 33.5 дахь хэсэг мөн зүйлийн 33.13 дахь хэсгийн байгууллагад өгөх гэснийг тус тус хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал 72,7 хувиар дэмжигдлээ. 33 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

34 дүгээр зүйл. 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн тухайн улирлын хамаарах хагас жилийн төрийн санхүүжилтийг гэснийг Сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн /С1, Т1/ хэсгийг дараагийн жилд гэж өөрчилж, 34.6.5 дахь заалтын бусад удирдах албан тушаалтан гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 34.5.6 дахь заалт, 34.12, 34.13 дахь хэсэг тус тус нэмэх.

34.5.6. Мөнгөн бус хандив өгч байгаа тохиолдолд хандивлагчтай хандивын гэрээг бичгээр байгуулж, гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах.

34.12. Хуулийн этгээд намд хандив өгсөн бол хандивын хэмжээ зориулалтыг нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайландаа тусгана.

34.13. Намын санхүүгийн тайланд аудит хийхээр гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд хандивын талаарх баримт мэдээллийг хандивлагчаас гаргуулан авна. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ. Үүгээр 34 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

35 дугаар зүйл. Төслийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийн заасан худалдан борлуулах гэснийг заасны дагуу захиран зарцуулах гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. Санал 72,7 хувиар дэмжигдлээ. 35 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

36 дугаар зүйл. 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн хөрөнгийн баланс гэснийг хөрөнгийн бүртгэл гэж, 36.3.7 дахь заалтын арга хэмжээ зохион байгуулах ном болон хэвлэл, нийтлэл хэвлэн борлуулах үйл ажиллагаанаас гэснийг намтай холбоотой хэвлэл сурталчилгааны материал болон өөрийн хөрөнгийг захиран зарцуулах замаар гэж, 36.14 дэх хэсгийн бодлогын судалгааны байгууллага зэрэг түүний дэргэдэх харьяа байгууллагын санхүүгийн тайланг гэснийг намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж, харьяа байгууллагын санхүүгийн мэдээллийг гэж тус тус өөрчилж, 36.3.5, 36.3.6, 36.4.9 дэх заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 36.5, 36.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

36.5. Хөрөнгөд дараах зүйлийг бүртгэнэ.

36.5.1. барилга, 36.5.2. эзэмшлийн газар, 36.5.3. ажлын байрны тоноглол, техник хэрэгсэл, 36.5.4. бэлэн мөнгөний үлдэгдэл, 36.5.5. хуримтлал, 36.5.6 бусад хөрөнгө.

36.6. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага намын санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, хөрөнгө, орлого, зарлагын ангиллыг тодорхойлон тайлагнах журмыг Сонгуулийн төв байгууллагатай хамтран энэ хуульд нийцүүлэн батална. Ажлын хэсгийн гаргасан саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,6 хувиар дэмжигдэж байна. 36 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

37 дугаар зүйл. 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн тайлангаа нэгдсэн байдлаар гэснийг нэгтгэсэн тайланг гэж,

37.6 дахь хэсгийн бүртгэл болон санхүүгийн гэснийг бүртгэлийн гэж тус тус өөрчилж, 37.2 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр, 37.4.1 дэх заалтын намын гишүүний тоо гэснийг 37.7 дахь хэсгийн эсхүл төлөөллийн төв байгууллагагүй бол удирдах дээд байгууллагаас гэснийг тус тус хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 63,7 хувиар дэмжигдэж байна. 37 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

38 дугаар зүйл. 38 дугаар. Төслийн 38 дугаар зүйлийн гарчгийн тайланг аудитын байгууллагаар гэснийг санхүүгийн тайланг гэж, 38.2, 38.9 дэх хэсгийн аудитор гэснийг аудитын хуулийн этгээд гэж, 38.2 дахь хэсгийн баримт материалтай гэснийг баримт бичигтэй гэж, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийн аудиторын гэснийг аудитын гэж, 38.5 дахь хэсгийн тохиолдолд гэснийг этгээд гэж, 38.9 дэх хэсгийн тайланг гаргахад хэрэглэсэн бичиг баримт, баримт бичиг, нягтлан бодох бүртгэл гэснийг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт гэж, 38.10 дахь хэсгийн баталгаа гаргахад хангалттай гэснийг баталгаа гаргана гэж, 38.14 дэх хэсгийн шалгалтын тэмдэглэлийг гэснийг аудитын дүгнэлтийг гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 38.6, 38.8, 38.13 дахь хэсгийг тус тус хасах. 36 Энэ дээр чинь ажлын хэсэг энэ тэр гэдгээ бичээгүй юм байна шүү дээ. Саяын ажлын хэсгийн гэсэн гаргасан саналыг дэмжье. Санал хураалт. Энийгээ бичээрэй та нар. 72,7 хувиар санал дэмжигдэж байна.

Дараагийн санал. Төслийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.7, 38.12 дахь хэсгийг 38.1, 38.5, 38.9 дэх хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах.

38.1.Нам жилийн эцсийн санхүүгийн тайланд жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Аудитын тухай хуульд заасан шаардлагыг хангасан аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, аудит хийсэн санхүүгийн тайланг Сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

38.5.Энэ хуулийн 38.1-д заасан аудитын хяналтыг хийхдээ намын санхүүгийн тайлан болон аудитын хуулийн этгээдийн ирүүлсэн эрсдэлд үндэслэн орон нутгийн салбар нэгж байгууллагын 5-аас доошгүй хувийг түүвэрт хамруулна.

38.9.Аудитын хуулийн этгээд намын санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэл бусад баримт бичиг болон намын гүйцэтгэх төв байгууллагаас өгсөн тайлбар тодруулгыг үндэслэн холбогдох олон улсын стандартын дагуу шалгаж, баталгаажуулсан дүгнэлт, тайлан гаргана. Ажлын хэсгийн саналыг дэмжих санал хураалт явуулъя. Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Энэ аудитын хуулийн этгээд гэдэг чинь төрийн аудитыг хэлээд байна уу?

Н.Энхболд: Аль алийг нь.

Ж.Батсуурь: Аль алиныг нь хэлж байгаа юу?

Н.Энхболд: Энэ дээр чинь зөвхөн хувийнх нь үү?

Ж.Батсуурь:Тэгэхээр намын энэ юутай холбоотой тайлан юутай хяналттай холбоотой асуудал өгвөл заавал төрийн аудитаар биш аль нэгэн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулж болно гэсэн агуулга уу?

Н.Энхболд: Тийм. Түрүүн бид нар санал хураахдаа ийм нэг тайлбар бас байсан. Төрөөс авсан санхүүжилттэй холбоотойг бол төрийн санхүүжилтийн байгууллагаар. Бусад юу аудитын байгууллагаар. Бусад хандив юу байдаг юм.

Ж.Батсуурь: Тэгэхдээ нөгөө тайлан гарна гэдэг чинь тайлан чинь салахгүй шүү дээ төрийнх юуных гэж. Тийм болохоор наадах чинь.

Н.Энхболд: Орж байгаа орлогынхоо эх үүсвэрээс хамаарч төрөөс бол төрийнх нь, бусдыг нь бол хувийнхаар хийж болохгүй.

Ж.Батсуурь: Төрийнхөөр бол тайлангаа биш санхүүжилтээ л хянуулна. Тайлангаа хянуулахгүй нь байна шүү дээ зөв үү? Тайлангаа бол хувийн аудитын байгууллагаар хийх юм байна. Зөвхөн төрөөс авсан санхүүжилтээ л хянуулна уу гэхээс, тэр бол тайлангаа бол хянуулахгүй байна гэж ойлгож байна шүү дээ, зөв үү? Тэгэхээр төрийн аудитын байгууллага тайланг хянах эрхгүй гэсэн үг биз, тэгж ойлгож болох уу? Тэгж уншигдаж байна шүү дээ угаасаа энэ чинь агуулгын хувьд.

Н.Энхболд: Хэн хариулах вэ?

Ж.Батсуурь: Намын, намын санхүүгийн тайлан төрийн аудитын байгууллага хийх эрхгүй л гэсэн агуулга шүү дээ энэ чинь.

Н.Энхболд: Ажлын хэсэг Бундхорол.

Б.Бундхорол: Батсуурь гишүүний асуултад хариулъя. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Аудитын тухай хуульд одоогоор намын санхүүгийн тайланг хувийн аудитын компани хянахаар бол хуульчлагдсан байгаа. Энэ хуулийн дагуу энэ хууль Улс төрийн намын хуульд ч гэсэн хяналт нь хэвээрээ орж ирж байгаа. Харин зөвхөн төрөөс олгож байгаа санхүүгийн дэмжлэгийн хувьд бол төрийн аудитын байгууллага, СЕХ-ны төсвийн багцад суусан хүрээнд нь цаглаварт хугацаандаа хяналт шалгалт хийхээр хуулийн төсөлд бол тусгагдсан байгаа.

Н.Энхболд: Батсуурь гишүүн тодруулъя гэж байна.

Ж.Батсуурь: Үгүй ээ ойлгож байна л даа. Тэгэхдээ ингэж байгаа юм. Яг өөрийн чинь хэлснээр бол төрөөс өгсөн санхүүжилтийг л төрийн аудитын байгууллага хянаана уу гэхээс ер намын

санхүүгийн тайланг бол хянахгүй юм байна гэж ойлголоо шүү. Зөв үү? Ойлголоо.

Н.Энхболд: Санал хураалт явуулъя. Ойлгоцлоо. Хариулт өгч дууслаа. Санал хураалт. 72,7 хувиар дэмжигдлээ. 38 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

39 дүгээр зүйл. Төслийн 39 дүгээр зүйлийн гарчгийн тайланг нягтлан шалгах гэснийг тайлангийн хяналт гэж, 39.1 дэх хэсгийн хэлбэр болон агуулгын хувьд зөв бодитой эсэх энэ хуулийн 5 дугаар бүлэгт гэснийг энэ хуульд гэж, нягтлан шалгах гэснийг хянах гэж, 39.2 дахь хэсгийн ажлын 15-аас гэснийг ажлын 5-аас гэж, 39.3 дахь хэсгийн хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн гэснийг хүлээн авч хянаад 4 дүгээр сарын 5-ны гэж, 39.4 дэх хэсгийн нягтлан шалгах ажиллагаа гэснийг хяналтын ажиллагаа гэж, 39.5 дахь хэсгийн тухайн алдаа, зөрчлийг арилгаж Сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу гэснийг Аудитын хуулийн этгээдийн тогтоосон хугацаанд тухайн алдаа зөрчлийг арилгаж гэж, 39.7 дахь хэсгийн тайланг нягтлан шалгах ажиллагааны гэснийг санхүүгийн тайланг хянах гэж тус тус өөрчилж, 39.4.3, 39.4.4, 39.6 дахь хэсгийг болон мөн зүйлийн 39.7 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг тус тус хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. Асуулт саяынх чинь хүчингүй шүү. Энэ санал хураалт байхгүй. Батсуурь гишүүн. Батсуурь гишүүний микрофоныг өгье.

Ж.Батсуурь: Улс төрийн намын, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын энэ төсөл дээр энэ санхүү, тайлантай холбоотой бараг маш олон заалт, бүлэг байна л даа. Тэгэхээр энийг ингээд хараад байхад энэ нөхцөлөөр би өөрөө бас энэ санхүү чиглэлийн хүн. Энэ намын нягтлан чинь ер нь мэргэшсэн нягтлан байна гэж заасан юм байна уу? Зүгээр нягтлан бол энэ тайланг гаргаж чадахгүй л хэмжээнд л өндөр шаардлага тавьж байна л даа. Тэгэхээр яг ингэж хуульчилсан юм байна

уу? Үгүй ээ тэрэн дээр байхгүй, байхгүй. Яг энэ үйлдлүүдийг хийнэ гэх юм бол энийг бол зүгээр мэргэшиээгүй нягтлан бол энэ тайланг гаргаж чадахааргүй л үйлдэл байна л даа. Үгүй ээ, үгүй. Тэгээд зааж өгөхгүй бол энэ чинь бөөн л будилаан болно л доо. Үгүй ээ энэ чинь өөрөө.

Н.Энхболд: Яг Намын тухай хуульд ингээд яг тийм мэргэжлийн хүн тэгж ав гээд заачихаар бас нэг жоохон зохисгүй оргиод. Яах вэ дээ тэгээд бусад хууль тогтоомжийг нь дагуу гэрээгээр янз бүрээр авч болоод ажиллуулж болдог шүү дээ мэргэжлийн хүмүүс тийм ээ. Тэгээд тухай тухайн үедээ зохицуулаад явах боломжууд нь байгаа байх гэж бодож байна. Санал хураалтаа явуулъя. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

39 дүгээр дахин дахиад нэг санал байна. Төслийн 39 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 39.5 дахь хэсэг нэмэх.

39.5.Төрийн аудитын байгууллага төрөөс намд олгосон санхүүжилт гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусган тайлагнана. Ажлын хэсгийн санал дэмжье. 63,6 хувиар санал дэмжигдэж байна. 39 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

40 дүгээр зүйл. 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн мэдүүлэх гэснийг мэдэгдэх гэж, 40.2 дахь хэсгийн нягтлан шалгах ажиллагааны явцад гэснийг хянах явцад гэж тус тус өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдэж байна. 40 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

41 дүгээр зүйл. Төслийн 41 дүгээр зүйлийн гарчгийн төрөөс олгосон санхүүжилтийг буцааж төлөх гэснийг аудитын дүгнэлтээр тогтоосон алдаа зөрчлийн үр дагавар гэж өөрчилж, 41.2, 41.3 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 41.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

41.1.Энэ хуулийн 39.6-д заасан хугацаанд алдаа зөрчлөө арилгаж санхүүгийн тайлангаа шинэчлэн ирүүлээгүй бол сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн /С1, Т1/ хэсгийг дараагийн жилд олгохгүй. Ажлын хэсэг санал гаргасан. Дэмжье. Хүрч байгаад, тэр хүрч байж болъё. 63,6 хувиар дэмжигдэж байна. 41 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

42 дугаар зүйл. Төслийн 42 дугаар зүйлийн гарчгийн эсхүл ил болгоогүй гэснийг болон 42.4 дэх хэсгийг тус тус хасаж, 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

42.1.Нам энэ хуулийн 34.5.3, 34.5.4-д заасны дагуу хандивыг ишлжүүлээгүй бол Сонгуулийн төв байгууллагын шийдвэрээр тухайн нам хууль бусаар авсан хандивыг 3 дахин өсгөсөн дүнгээр Сонгуулийн төв байгууллагад төлнө. Ажлын хэсгийн санал дэмжье. Санал хураалт. 54,5 хувиар дэмжигдэж байна. Оюунчимэг гишүүнээ саналаасаа хоцорчихсон байна шүү. 42 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

43 дугаар зүйл. 40. Төслийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь хэсгийн 4 дүгээр сард гэснийг 5 дугаар сард гэж, зохих тоогоор гэснийг тухай бүр эмхэтгэж гэж тус тус өөрчлөх. Санал хураалт. Ажлын хэсгийн санал. 63,6 хувиар санал дэмжигдлээ. 43 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

44 дүгээр зүйл. Төслийн 44 дүгээр зүйлийн 44.2.2 дахь заалтын болон тарсан гэснийг хасаж, мөн зүйлийг 7 дугаар зүйлд нэгтгэх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. Тэгнэ. 72,7 хувиар санал дэмжигдлээ. 44 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

45 дугаар зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? 45. 46, 46.1. 45 дугаар зүйл дээр санал, асуулт алга. Хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

46 дугаар зүйл дээр ажлын хэсгийн ахлагчаас санал гаргая. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Энэ 44 дэх санал буюу 46 дахь зүйлийн энэ үйлчлэх хугацаа заасан саналыг ажлын хэсэг буцааж татан авч байгаа юм. Тэгээд хуульд зааснаараа 1 сарын 1-ээсээ явах юм байгаа юм.

Н.Энхболд: Ажлын хэсэг саналаа татаж авлаа. Санал хураахгүй. Үүгээр зарчмын зөрүүтэй саналуудаар санал хурааж дуусаж байна. 46 дугаар зүйлийг хэлэлцэж дууссанд тооцлоо. Санал гараагүй учраас.

Найруулгын санал. Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: 45 зүйл анги зүйлтэй хуулийг эхнээс нь явж байна. Энэ нөгөө анх өргөн баригдахдаа сумын анхан шатанд намын нөгөө юугүй болно гэж яаж байсан өргөн баригдаж байсан тэр хасагдсан гэж ойлгож болох уу? Үндсэндээ тэр аль ч заалтуудад нь гарч ирэхгүй байна шүү дээ. Тийм ээ. Ард иргэдийг нөгөө улс төржилтөөс байхгүй болгох, тухайн намынхаа дүрмээр явна гэсэн үг үү? Хуульд бол онцгойлон заасан юм байхгүй. Уул нь Содбаатар даргын танилцуулж байсан юун дээр бол юу байхгүй байсан шүү дээ. Тийм ээ Бумдариа?

Н.Энхболд: Хүн хариулах уу?

Ж.Батсуурь: Анх танилцуулж байсан, анх танилцуулж байсан төсөл дээр бол анхан шатанд намын байгууллагын бүтэц байхгүй болгохоор оруулж ирж байсан зөв үү?

Н.Энхболд: Тийм юм байгаагүй юм шиг санах юм эхнээсээ.

Ж.Батсуурь: Байгаагүй юу?

Н.Энхболд: Бямбажаргал зөвлөх хариулах уу? Байсан, байгаагүйг нь л

хэлчих тийм. 2 номерын микрофон Бямбажаргал зөвлөх.

А.Бямбажаргал: Өргөн барьсан төсөлд тийм зохицуулалт байгаагүй.

Н.Энхболд: Баярлалаа. Найруулгын санал. Ингээд саяынхаар Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр нь анхны хэлэлцүүлэг хийж, хэлэлцэж дууслаа.

Одоо найруулгын саналуудаа явах уу? Энийгээ явах уу? Найруулга.

1.Төслийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3.1 дэх заалтын нийгмийн гэсний дараа сонирхлын гэж тус тус, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн албан тушаалтны зүгээс гэсний дараа заналхийлэх гэж, 29 дүгээр зүйлийн 29.3, 29.6 дахь хэсгийн тайланг гэсний өмнө санхүүгийн гэж, 29.9 дэх хэсгийн тайланд гэсний өмнө мөн санхүүгийн гэж тус тус нэмж, 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын төрийн төрийн санхүүжилт авах эрх үүсэх жил гэснийг төрийн санхүүжилтийн эрх үүсэх жил гэж, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг мөшигөн хавчих гэснийг мөрдөн мөшигөх гэж, 5.6 дахь хэсгийн бичиг баримтад гэснийг баримт бичигт гэж, 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын хууль тогтоомжид гэснийг хууль, юу нь хуульд тогтоомжид гэснийг хууль тогтоомжид гэж, 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн байдлын гэснийг байдлыг хангах гэж, 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсгийн хийж гэснийг хийлгэж гэж, 12.3.8 дахь заалтын хөрөнгийн мэдээ гэснийг Хөрөнгийн мэдээлэл гэж, 12.4 дэх хэсгийн хөрөнгийн мэдээнд гэснийг хөрөнгийн мэдээлэлд гэж, 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтын гишүүнчлэлээс гэснийг гишүүнээс гэж, 23 зүйлийн 23.1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн 10 хоногийн гэснийг 10 өдрийн гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн гишүүдийн гэснийг гишүүний гэж, 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн Улсын дээд шүүх гэснийг Улсын дээд шүүхийн гэж, 29.9 дэх хэсгийн тооцон бодоход гэснийг тооцоолоход

гэж, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн шийдвэрлүүлнэ гэснийг шийдвэрлэнэ гэж, 36 дугаар зүйлийн 36.16 дахь хэсгийн баримтыг гэснийг баримт бичгийг гэж тус тус өөрчилж, 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтын зорилго бодлогыг тодорхойлсон гэсний дараах үндсэн гэснийг, 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсгийн хэдийд ч гэсний дараах намаас гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтын нам гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.4.3 дахь заалтын буюу гэснийг, 30 дугаар зүйлийн 30.1,2, 30.3 дахь хэсгийн үндэсний гэснийг тус тус хасах.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн ажлын хэсгээс гаргасан найруулгын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Ордог юм, бүх хуулиудад тэгж гарч байгаа. Тийм. 54,5 хувиар санал дэмжигдэж байна. Үүгээр Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дагаж хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг хийнэ. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд байгаа.

1 дүгээрт төслийн 1 дүгээр зүйлийн энэ зүйлийн, энэ хуульд нийцүүлэн гэснийг хасах. Ажлын хэсгийн санал байна. Санал хураалт явуулъя. 63,6 хувиар санал дэмжигдэж байна. Дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

2 дугаар зүйл. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

2 дугаар зүйл.Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль тухай

хуультай нийцүүлэх арга хэмжээг 2024 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш 6 сарын дотор авч хэрэгжүүлэх бөгөөд энэхүү өөрчлөлтөө Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ. Ажлын хэсгийн санал дэмжье. Энэ 63,6 хувиар энэ санал дэмжигдэж байна. Ер нь энэ томъёолол бол улс төрийн намуудын хэлэлцүүлгийн үеэр мөн ажлын хэсэг, хууль санаачлагч нартай бүгдтэй нь ярьж, тал талаас нь ойлголцож байж томъёолж орж байгаа шүү санал гэдгийг хэлчихье. 57,9 хувиар дэмжигдэж байна. 2 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

3 дугаар зүйл.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

3 дугаар зүйл.Намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, намын санхүүгийн тайлан гаргах, тайланг нийтэд мэдээлэх, намыг идэвхгүйд тооцохтой холбоотой зохицуулалт нь Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн өдрөөс хэрэгжинэ. Ажлын хэсгийн гаргасан санал. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ. 3 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

Дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл дээр саналтай, асуулттай гишүүн байна уу? Байхгүй байна. 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

5 дугаар зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Байхгүй байна. 5 дугаар зүйлээр хэлэлцэж дууслаа. Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. 1 дүгээр зүйл дээр. Ажлын хэсгээс гаргасан саналын дагуу Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль

санаачлагчид нь буцаах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Энэнийг хэлэх хэрэг байна уу? Байхгүй тийм ээ. Одоо энэ чинь өөр юм байгаа юм байна шүү дээ тэмдэгтийн тухай юм. Нэг томъёололтой.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол нэг санал байна. Төсөлд доор дурдсан агуулга. 1 дүгээр зүйлээр нь хэлэлцэх байх энэ чинь бас. 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн алга байна. 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

2 дугаар зүйл. Төсөлд дор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх. 2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн улс төрийн нам, шашны байгууллагыг гэснийг шашны байгууллагыг гэж, 15.2.3, 15.2.4, 15.2.5 дахь заалтын дугаарыг 15.2.1, 15.2.2, 15.2.3 гэж тус тус өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Энэ яагаад өөр, өөр юмнуудыг ингээд өгчихсөн юм бэ? 63.6 хувиар дэмжигдэж байна. Өөр зүйлүүд бий юу?

3 дугаар зүйл дээр санал, асуулттай гишүүн байхгүй байна. 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл тус бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд танилцуулж, санал хурааа. 1 дүгээр зүйл төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 мянган нэгжтэй гэснийг тухайн мөнгөн дүнг эсхүл мөнгөн бус хөрөнгө үйлчилгээг зах зээлийн дундаж ханшаар үнэлсэн дүнг 1,5 дахин үржүүлсэнтэй гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн байна. Санал хураалт явуулъя. 1,5 дахин

гэдэг үгээ бас сайн хараарай. Ингээж бичиж байна уу? Бусад хууль дээр ямар байна. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуулийн 2 дугаар зүйл дээр санал асуулттай гишүүн алга байна. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулгатай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. Энэ тийм байна, тийм байна. Уучлаарай, уучлаарай. 1 дүгээр зүйлээ дуусгаагүй байсан байна. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн нэг банк дахь нэг дансаар хүлээн аваагүй бол 10 мянган нэгжтэй гэснийг банкны нэг дансаар хүлээн аваагүй бол тухайн орлогын мөнгөн дүнг 2 дахин үржүүлсэнтэй гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдэж байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 10 мянган нэгжтэй гэснийг тухайн мөнгөн дүнг 2 дахин үржүүлсэнтэй гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжих санал хураалт явуулъя. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 10 мянган нэгжтэй гэснийг тухайн хандивын мөнгөн дүнг 2 дахин үржүүлсэнтэй гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 63,6 хувиар санал дэмжигдлээ. 2 дугаар зүйлээр түрүүн санал хураалт явуулчихсан. Ингээд энэ хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналууд. 1 дүгээр зүйл дээр санал, асуулт байхгүй байна. 1 дүгээр зүйл хэлэлцэж дууслаа.

2 дугаар зүйл дээр санал байна. Ажлын хэсгээс гарсан. Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтын энэ хуулийн 3.1.6-д заасны дагуу гэснийг хасах. Саналыг

дэмжих санал хураалт явуулъя. 63,6 хувиар санал дэмжигдэж байна.

Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй байна. Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналууд. 1 дүгээр зүйл дээр санал байна. Ажлын хэсгээс боловсруулж ирүүлсэн. Тийм үү? 1 дүгээр зүйл дээр доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх.

1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйл доор дурдсан агуулгатай 3.2 дахь хэсэг нэмсүгэй.

3.2.Улс төрийн намыг шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг намын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, намын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэ хууль үйлчлэхгүй. Ажлын хэсгийн саналыг дэмжье. 63,6 хувиар дэмжигдэж байна.

Мөн хуулийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. 1 дүгээр зүйл дээр төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх.

Монгол Улсын 1 дүгээр зүйл.Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 85 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 85.6 дахь хэсэг нэмсүгэй.

85.6.Улсын дээд шүүхийн Тамгын газар нь энэ хуулийн 25.8.8-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий нэгжтэй байна. Санал гаргасан ажлын хэсэг дэмжье. 63,6 хувиар санал дэмжигдэж байна.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 25.8.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

25.8.8.Улс төрийн намыг бүртгэх, бүртгэлээс татгалзах, идэвхгүй болон идэвхтэйд тооцох, татан буулгах, тамга тэмдгийн хяналтын, регистрийн, хувийн хэргийн дугаар, гэрчилгээ олгох, хүчингүй болгох, эдгээртэй холбогдсон бүртгэл болон намын нэрийн сан хөтлөх, лавлагаа олгох. Ажлын хэсгийн санал дэмжье. Энэ яачхав? Батсуурь гишүүнийх гарсангүй дээ. Санал хэлэх үү? Тэгээд ч өөр хэн байна. Тийм, татаж авч байгаа юм уу? Батсуурь гишүүний микрофон өг дөө.

Ж.Батсуурь: Миний кноп дутуу дарагдчихлаа. Дахин санал хурааж өгнө үү.

Н.Энхболд: Батсуурь гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Үгүй ээ, энэ минийх бас ажилладаггүй шүү яачхав. 54,5 хувиар санал орчихсон байна, дэмжигдлээ. Саяын саналыг хүчингүй болгохыг тооцсон тул түрүүчийн уншсан томъёоллоор дахин санал хураая. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ. Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл дээр санал хураалт явуулж дууслаа.

2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Монгол Улсын шүүхийн тухай хуульд оруулах хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар зүйл бүрээр санал хураана.

1 дүгээр зүйл.Төслийн 1 дүгээр зүйлийг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 63,6 хувиар санал дэмжигдэж байна. 1 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

Төсөлд дор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх.

2 дугаар зүйл.Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн ажлын албанд гэснийг Тамгын газарт гэж, 15 дугаар зүйлийн гарчгийн ажлын алба гэснийг Тамгын газар гэж, 15.1 дэх хэсгийн ажлын албатай гэснийг Тамгын газартай гэж, мөн хэсгийн хороо батална гэснийг хороо батална. Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг Улсын Их Хурал тогтооно гэж, 15 дахь хэсгийн ажлын албаны гэснийг Тамгын газрын гэж тус тус өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт явуулъя. 54,5 хувиар энэ санал дэмжигдэж байна.

Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хасаж, 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

7.6.Хороо улс төрийн намын үйл ажиллагааны талаарх дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Улс төрийн намын тухай хуулийн 9.10-д заасан мэдээллийн сан бүрдүүлж нийтэд мэдээлэх, 7.6.2.төрийн санхүүжилт авах тухай хүсэлт гаргах маягтыг батлах, 7.6.3.нам дахь хандивын бүртгэлийг хөтлөх маягтыг батлах, 7.6.4.хуульд заасан үндэслэл журмын дагуу намыг тараах тухай санал гаргах, 7.6.5.намд олгох төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоож, төсөвт суулган олгох, 7.6.6.намд төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг олгох, шийдвэрлэх, 7.6.7.Улс төрийн намын тухай хуулийн 8.9, 10.3-д заасны дагуу хяналт хэрэгжүүлэх, 7.6.8.Улс төрийн намын тухай хуулийн

26.6-д заасны дагуу шийдвэр гаргах, 7.6.9.Улс төрийн намын санхүүгийн тайланд хяналт тавих, 7.6.10.Улс төрийн намын тухай хуульд заасан бусад бүрэн эрх гэсэн Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 63,6 хувиар санал дэмжигдлээ. 2 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. 3 дугаар зүйлээр санал хураалт дууслаа.

4 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна. 4 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа. Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Улс төрийн намын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоолыг, тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналууд байгаа. Төслийн 1 дэх хэсгийн нарийвчилсан журам арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Оюун-Эрдэнэ/ гэснийг журам батлах зохион байгуулахтай холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын дээд шүүх /Ганзориг/ гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Тогтоолын төслийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулъя. Энэ тогтоолыг Улс төрийн намын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 63,6 хувиар энэ санал дэмжигдлээ. Тогтоолынхоо төслийг хэлэлцэж дууслаа.

Улс төрийн намын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл. Энэ дээр чинь санал хураах юмнууд байхгүй тийм ээ, хаана байна вэ? Улс төрийн намын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн

байна уу? Алга байна. 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа. Улс төрийн намын тухай хууль хүчингүй болсон тухай болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. Одоо юу байна вэ?

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Тогтохсүрэн гишүүн чуулганы өргөжсөн хуралдаанд танилцуулна. Ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа. Бид дараагийн асуудалдаа орно.

13.25 цаг

Хоёр. “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэж эхэлнэ. 2 жижигхэн тогтоол байна шүү хаана байна вэ тогтоол? Минийх хаана байна вэ? Байнгын хорооноос нэг ийм санал ирсэн юм алив. Гишүүд байж байгаарай. Монгол Улсын Их Хурлын гишүүн Адьшаа, Тогтохсүрэн нараас Их Хурлын даргад тавьсан санал байгаа. Тогтоолын төслийн талаар.

Үүнийг эхлээд уншиж танилцуулна байх, зөв байх. Энэний дагуу Байнгын хорооноос нэг тогтоол гаргая гэсэн ийм санал байгаа. Тэгэхээр Тогтохсүрэн гишүүн та нөгөө Адьшаа гишүүн та хоёрын гаргасан саналынхаа Их Хуралд гаргасан саналынхаа талаар товчхон танилцуулга хийчих. Тэгээд би төслөө танилцуулаад явуулчихъя. Оруулчихсан. Одоо харин зүгээр танилцуулга хийчих. Жороо морины тухай юм уу. Танилцуулчихъя яах вэ энэ чинь нэг албан ёсоор санал тавиад. Байгаа дараа нь байгаа, дотроо орчихсон юм уу?

Тогтоолын төсөл түрүүн би хэлсэн тараачихсан байж байгаа. 2 гишүүн Их Хурлын даргад хүсэлт гаргаж, асуудал тавьсны дагуу Байнгын хорооноос нэг ийм тогтоол гаръя гэж байгаа юм. Би төслийг нь уншаад танилцуулчихъя. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын төсөл. Чиглэл өгөх тухай. Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсгийг Үндсэн Улсын Их Хурлын ТББХ-ноос тогтоох нь.

Нэг. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Оюун-Эрдэнэ/, зохион байгуулах хорооны дарга Монгол Улсын Шадар сайд /Амарсайхан/ нарт даалгасугай.

1. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.19 дэх хэсэгт заасныг баримтлан Үндэсний их баяр наадмын хөтөлбөрт жороо морины уралдааныг оруулж зохион байгуулах.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Энхболд/-д даалгасугай. Тогтоолыг баталсан өдрөөс дагаж мөрдөнө гэсэн ийм тогтоолын төсөл байгаа юм. Асуух, саналтай гишүүн байна уу? Алга байна. Тэгвэл саяын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ, Тогтохсүрэн. Амарсайхан сайд. 63,6 хувиар тогтоол батлагдлаа. Баярлалаа.

13.28 цаг

Гурав. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Одоо нэг асуудал байгаа. Хуулийн давхардал, хийдлийг хийдэл, зөрчлийг

арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Шадар сайд Амарсайхан танилцуулъя.

С.Амарсайхан: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндэсний их баяр наадмын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан дагаж мөрдөж байна. Гэвч Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зарим зохицуулалт нь бусад хуулийн зохицуулалттай зөрчилдөх, хийдэл үүсэх зэрэг нь хуулийг нэг мөр хэрэглэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэж байна гэж дүгнэж байгаа.

Тухайлбал Үндэсний их баяр наадмын тухай хууль болон Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд Үндэсний их баяр наадам Ардын хувьсгалын ойн баяр 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15 гэж нийтээр тэмдэглэх буюу нийтээр амрах өдрүүдийг заасан байдаг. Харин Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6-д Үндэсний их баяр наадам Ардын хувьсгалын ойн баяр 7 дугаар сарын 11, 12, 13, 14, 15 гэж 7 дугаар сарын 10-ны өдрийг орхигдуулсан нь зөрчлийг үүсгэж, хуулийг нэг мөр хэрэглэхэд зөрчилтэй байдлыг үүсгэсэн байна.

Түүнчлэн Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-д улсын аварга, арслан цолтой бөх 9 даган түрүүлсэн тохиолдолд олгох цолны зохицуулалтыг орхигдуулсан нь мөн хийдлийг үүсгэж байна. Үүнээс гадна хуульд допинг хэрэглэхийг хориглох, хэрэглэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг суулгаж өгсөн боловч энэ нь зөвхөн улсын баяр наадмын

үндэсний бөхийн барилдаанд хамааралтай бөгөөд аймгийн баяр наадам түүнтэй адилхан баяр наадамд барилдсан бөхөөс допингийн шинжилгээг авах зайлиггүй шаардлагатай байна.

Мөн аймгийн баяр наадмын бөхийн барилдаанд 128-аас дээш 256 бөх барилдах боломжийг Үндэсний их баяр наадмын тухай хуульд хязгаарласан нь тухайн барилдаанд аймаг, сумын цолтой бөх болон залуу бөхчүүдийг барилдуулах нөхцөлийг хангаагүй хязгаарласан асуудал болсон байна. Түүнчлэн 1921 оноос эхлэн жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн Цэргийн баяр наадмыг зохион байгуулах, түүнд цол олгохтой холбоотой зохицуулалтыг Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмж тусгах шаардлагатай байна. Иймд хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дараах үзэл баримтлал, агуулгаар боловсруулаад байна.

Үүнд, 1 дүгээрт хууль хоорондын зөрчил, давхардал, хийдлийг арилгах, 2.Улсын баяр наадамд амжилт гаргасан бөхөд цол, олгох цолыг тодорхой болгох зохицуулалтыг нарийвчлан тусгах, 3.Тэгш ойн баяр наадамд 256 хүртэлх тооны бөх барилдаж болох эрх зүйн орчныг бүрдүүлэх, 4.Аймгийн баяр наадамд үзүүрлэсэн, шөвгөрсөн бөхөөс допингийн шинжилгээ авах шаардлагыг тусгах, 5.Монгол Улсад уламжлал ирсэн Цэргийн наадамд цол олгох эрх зүйн орчныг аймгийн баяр наадамд цол олгохтой адилтгах зохицуулалтыг тусгах зэрэг болно.

Хуулийн төсөл батлагдсанаар хууль хоорондын зөрчил арилж, уялдаа холбоо сайжрахын зэрэгцээ Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах эрх зүйн орчин сайжрах, улсын баяр наадмын үндэсний бөхийн барилдаанаас гадна аймгийн баяр наадам түүнтэй адилтгах баяр наадмын үндэсний бөхийн

барилдаанд барилдаж амжилт гаргасан бөхөөс тамирчны нэгэн адил шинжилгээ авах эрх зүйн орчин бүрдэх юм. Иймд хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

13.34 цаг

Өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудлууд дууслаа. Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын алба хуралдааны нэгдсэн чуулганы хуралдааны бэлтгэлийг сайн хангаарай. Баярлалаа. Хуралдаан дууслаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

Н.Энхболд: Шадар сайдад баярлалаа. Танилцуулга хийсэнд. Ажлын хэсгийг би танилцуулчихъя. ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Сайнзориг, Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Рэнцэнбямба байна уу, алга уу? ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Жамъянхүү, Монголын үндэсний бөхийн холбооны тэргүүн Магалжав, Допингийн эсрэг байгууллага Монголын допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх захирал Мөнхболд. Ийм ажлын хэсэг байна. Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулаад асуух гишүүн байна уу? Алга байна. Санал хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Тэгвэл хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Амарсайхан гишүүн, Амарсайхан сайд саналаа өгөөрэй. 11 гишүүн оролцож, 72,7 хувиар санал дэмжигдлээ. Батсуурь гишүүнээ уншчих уу? Байнгын хорооны санал, дүгнэлтийг уншчих уу та? Маргааш, нөгөөдөр. Тийм, өөрөө л мэд тийм. Байнгын хорооны санал дэмжигдсэн. Санал, дүгнэлт гаргана. Чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлтийг Батсуурь гишүүн танилцуулъя.

